

**СУМЫН ЗАСАГ ДАРГЫН “ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ-II” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2023.12.12

Сүүж

№	ЗДМХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрсэн түвшин, үр дүн	хувь
<b>Нэг. Хүний хөгжил</b>					
<b>1.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.</b>					
1	1.1.1. Эрүүл мэндийн төвийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулж, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцыг нэмэгдүүлж, чанартай, тэгш, хүртээмжтэй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	1	Сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барих	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдахаар 8,7 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй жишиг эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөв хийгдсэн. Үүнээс 5.6 тэрбум төгрөгийн үндсэн барилгын ажлыг азийн хөгжлийн банкны санхүүжилтээр, 602 сая төгрөгийн дэд бүтцийн ажлыг орон нутгийн санхүүжилтээр гүйцэтгэхээр төлөвлөн барилгын гүйцэтгэгчээр “Цомбон тоосго”, “Модерн Хас” ХХК барилгын компани шалгарсан.	100
2		2	Эрүүл мэндийн төвд стандартын шаардлага хангасан моргийн барилга шинээр барих	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдахаар 8,7 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй жишиг эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөв хийгдсэн. Үүнээс 5.6 тэрбум төгрөгийн үндсэн барилгын ажлыг азийн хөгжлийн банкны санхүүжилтээр, 602 сая төгрөгийн дэд бүтцийн ажлыг орон нутгийн санхүүжилтээр гүйцэтгэхээр төлөвлөн барилгын гүйцэтгэгчээр “Цомбон тоосго”, “Модерн Хас” ХХК барилгын компани шалгарсан.	100
3		3	Эрүүл мэндийн төвийн барилгыг цэвэр бохир усны төвлөрсөн төв шугамд холбох	ЭМТ нь 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар стандартын шаардлага хангасан ариун цэврийн өрөөтэй болсон.	100
4		4	Эрүүл мэндийн төвийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж, бүрэн камержуулан аюулгүй байдлыг сайжруулах	2023 онд ЭМГ-аас 7949979 төгрөгийн үнэ бүхий ариутгалын автоклав, спирометр аппарат, цус цусан бүтээгдэхүүн зөөвөрлөх хөргөгч зэрэг тоног төхөөрөмжүүдээр хангагдаж, тоног төхөөрөмжийн хангалт 93%-тай байна. ЭМЯ-аас эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, тоног төхөөрөмж хангалтыг нэмэгдүүлэхээр 50 сая төгрөгний нэмэлт санхүүжилт хийгдэж, 5ш нөүтбүүк, шүдний иж бүрэн сандал зэрэг тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийсэн.	100
5	1.1.2. Эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмж, автомашинаар хангах	1	Багийн эмч нарыг Mobile төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах	ЭМТ төв нь Дэлхийн банкны санхүүжилтээр 2019 онд “Mobile” тоног төхөөрөмжөөр хангагдсан.	100

6	Иргэдийн эрүүл мэндийн боловсролын дээшлүүлж, зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж, эрүүл, идэвхитэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	1	Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэгийг сум, багийн төвшинд зохион байгуулах	Аймгийн Засаг даргын нэрэмжит "Хүрч үйлчилье" нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд дотор, эмэгтэйчүүд, сүрьеэ, шүд зэрэг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээ хийгдэж, доторт 162 иргэн, эмэгтэйчүүдэд 73 иргэн, шүдний эмчид 2-17 насны 742 хүүхэд, сүрьеэ 152 иргэн, хэвлийн ЭХО-д 195 иргэн, цээжний рентгенд 75 иргэн тус тус хамрагдаж, онош тодруулахаар 6 иргэнийг лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлсэн. Үзлэгийн үр дүнд цөсний хүүдийн чулуу 10, цөсний хүүдийн ургацаг 6, бөөрний хоргүй хавдар 6, бөөрний чулуутай 2 иргэнийг тус тус илрүүлэн эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна.	100
7		2	Эрүүл мэндийн сайн дурын туслагч нарыг бэлтгэн, үе шаттай сургалтад хамруулах. Урамшууллын тогтолцоо бий болгох	2022 оны 7 сард Булган аймгийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн хөгжлийн төв хамтран Эрүүл мэндийн олон нийтийн ажилтан бэлтгэх 2 хоногийн сургалтад 5 иргэнийг хамруулж, гэрчилгээжүүлсэн. Цаашид тус 5 ажилтантай хамтран нэмж шинээр 15 сайн дурын ажилтан бэлтгэж, үе шаттай сургалтад хамруулахаар төлөвлөөд байна.	100
8		3	Эрүүл шүд - Эрүүл хүүхэд сумын хөтөлбөрийг боловсруулж шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулан ажиллах	2023 онд Булган дент шүдний эмнэлэг 1 удаа суманд ирж ажилласан. Эрүүл мэнд хөгжлийн зуун ТББ-ын эмч нарын баг амны хөндийн үзлэг, эмчилгээг 156 хүүхдийг хамруулан хийсэн байна. 2-5 насны 86 хүүхэд "Амны хөндийн эрүүл мэнд" сэдэвт сургалтыг хийж, амны хөндий эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Үзлэгт хамрагдсан хүүхдийн 58% нь амны хөндийн /шүд цоорол, гүйлсэн булчирхайн архаг үрэвсэл/ эмгэгтэй байсан. Цаашид эмчлэн эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэхээр Булган аймгийн ЭМГ, нэгдсэн эмнэлэгт хүсэлт уламжилж, 4-р улиралд аймгийн нэгдсэн эмнэлгийн шүдний эмчийг 5 хоногоор авч ажиллуулахаар шийдвэрлэсэн. 2024 онд шүдний эмчийг орон авч ажиллуулахаар төлөвлөн, 19 сая төгрөгийн өртөг бүхий шүдний үзлэг үйлчилгээний иж бүрдэлийг авсан.	70
9		4	"Элэг бүтэн Монгол" аяны хүрээнд ХБӨ эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлэх	Элэгний В, С вирус, элэгний хавдар илрүүлэх, урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Мөн эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд 288 иргэн хамрагдаж, элэгний хавдар В, С вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар гаргасан гарын авлага зөвлөмжийг тараасан. Жирэмсний хяналтад байгаа 31 эхийг элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд 100% хамруулж, гепатит вирусын халдвараас сэргийлэх талаар сургалтад хамруулж гарын авлага, зөвлөмж тараасан. ЭМТ-өөс нийт ЭМС-ын 196-р тушаалын дагуу сорьцыг 8 удаа тээвэрлэсэн. "Элэг Бүтэн Монгол" хөтөлбөрийн хүрээнд өрх сумын ЭМТ-ийн түвшинд гепатитийн вирусын оношилгоо эмчилгээний чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд бүрэн хамрагдсан. Эрүүл мэндийн төвийн ажилтанууд 100% В гепатитийн эсрэг вакцинжуулалтад хамрагдсан.	70
10		5	Халдварт бус өвчний эрт илрүүлэг, асуумж судалгааг авч зүрх судасны зонхилон	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж, эрт илрүүлэгт хамрагдаагүй 1219 иргэдийн судалгааг гаргасан. Халдварт бус өвчний эрт илрүүлэгт шаардлагатай оношлуур, эмнэлгийн хэрэгсэлээр 100% хангагдаж	100

			тохиолдох эмгэгийг эрт илрүүлж эрүүлжүүлэх	ажилласан. Артерийн даралт, чихрийн шижин өвчний үзлэгт 668 хүн хамрагдахаас 668 /100%/, хөхний үзлэгт 773 эмэгтэй хамрагдахаас 773 /100%/, умайн хүзүүний үзлэгт 187 эмэгтэй хамрагдахаас 159 /85%/-тай тус тус явагдаж байна. Хөх, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 100% хамруулж, өөрчлөлт илэрсэн 29 эмэгтэйд Хавдар судлалын үндэсний төвд шилжүүлэн онош тодруулж 2023 оны байдлаар хөхний хавдартай 2, умайн хүзүүний хавдартай 2, хавдарын урьдалтай 24 иргэнийг хавдар судлалын эмч нартай хамтран эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.	
11	1.1.4. Халдварт өвчний тандалт сэргийлэлтийг сайжруулж, эрт илрүүлэх идэвхтэй үзлэгийг зохион байгуулж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг дээшлүүлнэ.	1	Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх	Шинэ коронавируст халдвар болон бусад халдварт өвчний дэгдэлтийн үед шаардагдах хамгаалах хувцас, эм хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын судалгааг шинэчлэн гаргаж одоогийн байдлаар эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах өмсгөлийн 3 сарын нөөц бүрдүүлсэн.	100
12		2	Сүрьеэ, тэмбүү өвчнийг эрт илрүүлэх үзлэг зохион байгуулж, өвчтэй илэрсэн иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран сүрьеэ илрүүлэх, хавьталыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, сүрьеэгийн сэжигтэй болон сүрьеэгийн хавьтал болох 152 иргэнийг сүрьеэгийн эмчийн үзлэгт, цээжний рентген шинжилгээнд 75 иргэнийг, сүрьеэ илрүүлэх туберкулины сорилд 25 иргэнийг тус тус хамруулсан. Сүрьеэгийн хавьталын үзлэгийн хамрагдалт 91,2%-тай байна. 2023 онд 18 хүнээс цэрний сорьц тээвэрлэн, уушгины хэлбэрийн сүрьеэгийн 1 тохиолдол илрүүлэн эмийн эмчилгээнд хамруулсан. ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээнд зорилтот бүлгийн нийт 115 иргэнийг хамруулж, тэмбүүгийн нэг тохиолдлыг илрүүлэн, хавьталын хамт эмчлэн эрүүлжүүлсэн.	100
13		3	Цар тахлын үед авах хариу арга хэмжээг сайжруулан, сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, сувилалын газартай гэрээ байгуулж бэлэн байдлыг ханган ажиллах	Шинэ коронавируст халдвар болон бусад халдварт өвчний дэгдэлтийн үед шаардагдах хамгаалах хувцас, эм хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын судалгааг шинэчлэн гаргаж одоогийн байдлаар эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах өмсгөлийн 3 сарын нөөц бүрдүүлсэн.	100
14	1.1.5. Төрөлжсөн, сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлэн, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2	Эрүүл мэндийн төвийн сувилагчийн постыг бүрэн цахимжуулж, компьютерээр хангах	Эрүүл мэндийн төв нь сувилагчийн постыг бүрэн цахимжуулж, компьютер, принтер, ширээ сандлаар хангаж, ажиллах нөхцөлийг сайжруулсан. Одоогийн байдлаар 8 анхан шатны бичиг баримтыг цахимжуулсан байна.	100

15	1.1.6. Эрүүл мэндийн ажилтны чадавхыг сайжруулж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	1	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшил олгох, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	Хүний нөөцийн төлөвлөгөөний дагуу төгсөлтийн дараах сургалтад 2 эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. Эх баригч Н.Отгончимэгийг ЭХЭМҮТөвд мэргэжил дээшлүүлэх 1 сарын сургалтад хамруулсан. ХӨСҮТ-д бага эмч Н.Ариунцэцэгийн дархлаажуулалтын мэргэжилтэн бэлтгэх 3 сарын сургалтад тус тус хамруулсан.	100
16		2	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг дээд шатлалын клиникийн эмнэлэг болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад сургалтад хамруулж, туршлага судлуулах	Хүний нөөцийн төлөвлөгөөний дагуу төгсөлтийн дараах сургалтад 2 эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. Эх баригч Н.Отгончимэгийг ЭХЭМҮТөвд мэргэжил дээшлүүлэх 1 сарын сургалтад хамруулсан. ХӨСҮТ-д бага эмч Н.Ариунцэцэгийн дархлаажуулалтын мэргэжилтэн бэлтгэх 3 сарын сургалтад тус тус хамруулсан. 2023 оны 9-р сард “Сувилахуйн үнэлгээ” сэдэвт сургалтад ЭМТ-ийн дарга Т.Оюунчимэг, ахлах сувилагч Б.Сугармаа, сувилагч Н.Алтангэрэл, Б.Эрдэнэбулган нар хамрагдаж, Булган аймгийн НЭ-ийн дотор, арьс судлалын тасагт 9-р сарын 22-ны өдөр туршлага судалсан.	100
17		3	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллахад орон байрны дэмжлэг үзүүлэх	Эрүүл мэндийн төвийн 2 төрийн албан хаагчид орон байрны дэмжлэг үзүүлэх зорилгоор тус бүр 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Улаанбаатар хотоос шилжин ирсэн ЭМТ-ийн их эмчид түлээний 1 портер модыг олгосон.	70
18	1.1.7. Эх, хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан өвчлөл, эндэгдлийг бууруулна.	1	Хөгжлийн бэрхшээлтэй нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслээр хангаж, хүний нөөцийг чадавхжуулах	Нөхөн үржихүйн насны хөгжлийн бэрхшээлтэй 103 эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, жирэмслэлтээс хамгаалах эм, эмнэлгийн хэрэгслээр 100% үнэ төлбөргүй хангасан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ЭМТ-өөр үйлчлүүлэхэд зориулж үүдний хэсэгт тэргэнцэр, алхуулагч, таяг, баррель цагаан толгойг байрлуулж, ахлах сувилагч Б.Сугармаа, сургалтын арга зүйч Д.Ариунтунгалаг нарыг дохионы хэл сурах цахим сургалтад хамруулсан.	100
19		2	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах	Жирэмсний эхний 3-н сард хяналтад орсон эхийн эзлэх хувь 90%-тай байна. Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн эмч, Амгалан амаржих газрын эмэгтэйчүүдийн эмч нартай хамтран нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт 320 эмэгтэйг хамруулсан. Мөн хөх, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих эмэгтэйчүүдийг 100% хамруулж, өөрчлөлт илэрсэн 18 эмэгтэйг Хавдар судлалын үндэсний төвд шилжүүлэн онош тодруулж, 2023 оны байдлаар хөхний хавдартай 2, умайн хүзүүний хавдартай 2, хавдарын урьдалтай 13 иргэнийг хавдар судлалын эмч нартай хамтран эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.	100

20	1.1.8. Уламжлалт анагаах ухааны багц үйлчилгээг иргэдэд үзүүлэх	2	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг үзүүлэх өрөө, тоног төхөөрөмжөөр хангах	2022 оны 7 сараас уламжлалт анагаах ухааны их эмч авч ажилуулан иргэдэд уламжлалт анагаахын болон нөхөн сэргээх тусламж үйлчилгээг үзүүлж байна. СЭМТ-д хийгдэх Уламжлалт болон нөхөн сэргээхийн тусламж үйлчилгээний жагсаалтыг гаргаж батлуулсан. Уламжлалт эмчилгээний өрөөг тохижуулан, шаардлагатай тоног төхөөрөмж /УВЧ шарлагын аппарат, улаан гэрэл, бумба, давс, элсэн зам, төөнүүр/-өөр хангагдсан. Цаашид уламжлалт болон нөхөн сэргээх тусламж үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж аймгийн ЭМГ болон төсөл хөтөлбөрүүдэд уламжилсан.	100
<b>Эрүүл мэнд зорилтын дүн</b>				<b>96</b>	
<b>1.2. Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, төлөвшил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ.</b>					
21	1.2.1. Суралцагчдыг бие даан, бүтээлчээр суралцахууд суралцах боломж олгох орчинг бүрдүүлэн, тэдний авьяас, ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаан, орон нутгийн онцлогт зохицсон сургалтын хөтөлбөрийг баримтлан ажиллана.	1	Хүүхэд залуучуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор боловсролын байгууллагын сургалтын орчинг сайжруулах ажлыг хийнэ	Хүүхэд залуучуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгын хүрээнд Математикийн 2 кабинет, Мэдээлэл зүйн 1 кабинетийг бүрэн тохижуулсан. ЕБС-ийн "Хүүхдийн хөгжлийг дэмжих төв"-ийг шинээр байгуулан, засвар тохижилтын ажилд 9,3 сая төгрөгийг зарцуулсан. Цэцэрлэгийн хичээл, сургалтын хэрэглэгдэхүүн тоглоом, наадгайн баяжилтыг хийсэн. Мөн гадна талбайд 6 сая төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг сүүдрэвч, бүлгийн эцэг эхчүүдээс 1 хүүхэд 1 цемент аян зарлан эцэг эх, ажилчид хамтран явган хүний зам болон 10 машины зогсоол хийсэн. Анги бүлгүүдэд төсвийн хөрөнгөөр нийт 800,0 мян/төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг бэлтгэсэн.	100
22		2	Монголын үндэсний өв уламжлал, агуулга бүхий хүүхэд бүрийн хөгжлийг хангах сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх	Хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, Монгол уламжлал, ёс зан заншил, зан үйлд нөлөөлөх сургалт үйл ажиллагаагаа төлөвлөн явуулж байна. Суралцахуудын 6 чиглэлээр 1-р улиралд "Алтан намар", 2-р улиралд "Мөнгөн өвөл", 3-р улиралд "Монгол ёс заншил", 4-р улиралд "Хаврын баяр" гэсэн 4 аяны хүрээнд бүлэг бүр хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан агуулгыг сонгон авч нийт 585 цагийн сургалт үйл ажиллагааг бэлтгэн хүргэсэн байна.	70
23		3	Хүүхэд бүрийн авьяас хөгжлийг тасралтгүй хангах дугуйлан секцийн ажиллагааг тогтмолжуулан тодорхой амжилт гаргах	СӨБ олгох чиглэлээр уран уншлага, драм, зураг бүтээл, бүжгийн дугуйланг хичээллүүлж, нийт хүүхдийн 40%-ийг хамруулан сургаж байна. Эх хэл, байгалийн ухаан, техник технологи, гадаад хэл, урлаг спортын төрлөөр "Бичгийн жим", "Хүмүүн бичиг", "Залуу байгальч", "Залуу зохион бүтээгч", "Юмхнаар юм хийе", "Ноён бэрс", "Цэцгэн хуар", "Чихмэл тоглоом урлал", "Уран зангилаа", "Үндэсний болон жудо бөх", 11-18 хүртлэх нас насны ангилалд "Волейбол", "Си хэл", "Мэргэн мэтгэлцээний клуб" зэрэг 15 дугуйланд давхардсан тоогоор 302 хүүхэд хамрагдаж байна.	100

24	1.2.2. Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим агуулга, цахим хичээл боловсруулж, бүх сурагчдад чанар, үр дүнтэй хүргэнэ. Сумын бүх иргэдэд цахим сургалтаар суралцах боломж,	1	Цахим сургалтын платформууд үе шаттайгаар нэвтрүүлэн багш бүрийг мэдээлэл технологийн арга зүйд сургах	Боловсролын нэгдсэн систем болох ESIS шинэчлэгдэж байгаатай холбоотойгоор цахим дэлгүүрээс боловсролын платформ худалдан авах ажил хийгдсэн. Нөхөн хангалтын зардлаас 4,5 сая төгрөгийн үнэ бүхий “Дижитал сургуулийн платформ-багш систем”-ийг худалдан авч 35 багш, ажилтныг үе шаттай сургалтад хамруулсан. БШУЯ-ны PEARSON англи хэлний хөтөлбөр 6, 5-р ангийн нийт 122 сурагчдад хэрэгжиж байна. “ЭДҮТЭН” математикийн хөтөлбөр 11 сараас 3, 4-р ангийн нийт 140 сурагчдад хэрэгжихээр бэлтгэл ажлыг хангаж байна. Байгалийн ухаан, нийгмийн ухаан, урлаг гоо зүй, бага ангийн судлагдахуун тус бүрээр 4 баг болон 14 хоног тутамд “Сайн хичээл”-ийг цахим санд байршуулж байна. “Нарлаг” цэцэрлэгийн хэмжээнд “Цахим сан” бүрдүүлэн бүлгийн багш нар болон туслах багш нар бэлтгэсэн цахим хичээлүүдээ байршуулан ажиллаж байна. Одоогоор цахим сандаа 6 чиглэлийн дагуу 40-50 удаагийн цахим хичээл байршуулсан байна.	100
25	мэргэжил арга зүйгээр дэмжинэ.Бүх насны иргэдийн боловсролыг дээшлүүлж, хөгжүүлэх ажлыг “Насан туршийн боловсрол”-ын сумын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.	1	Цахим сургалтыг нэвтрүүлж бүх насны иргэдэд боловсрол олгох ажлыг зохион байгуулах	Иргэний боловсрол олгох чиглэлээр “Зочин багш” уулзалт ярилцлага, ёс суртахуун, төлөвшил олгох чиглэлээ “Соёлч-Цэвэрч” анги шалгаруулах уралдааныг зохион байгуулсан. Давсан урлалын сургалтад 5 иргэн, цаас, шүр, туузан урлалын сургалтад 10 сурагч хамрагдсан. Гоо зүйн чиглэлээр “Алтан намар” спортын тэмцээн, Олон улсын охидын өдрийг тохиолдуулан “Охид” тэмцээн, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр “Үсэглэлийн аварга” тэмцээн, “Шагайн харваа”-ны сургалтыг зохион байгуулж, сургалтад 8 сурагч, 2 насанд хүрэгч нийт 10 иргэн хамрагдсан. Шинжлэх ухааны боловсрол олгох чиглэлээр Мэргэжил бүхэн сайхан “АМЧБО” сургалт зэргийг тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 479 сурагч, 135 насанд хүрэгчдийг хамруулсан. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Эндээ-Хөгжил ТББ-тай хамтран тогоочийн 14 хоногийн сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 25 иргэн хамрагдаж, үнэмлэх болон чадамжийн гэрчилгээ авсан.	100
26	1.2.3. Багшлах боловсон хүчний мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжиж, тэдний ажлын үр дүнг дүгнэн урамшуулах, ажил мэргэжлээрээ манлайлсан тэргүүний	1	Боловсролын салбарын удирдлага, багш нарын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, богино, дунд, урт хугацааны сургалтанд хамруулах	2023 онд ЕБС, СӨББ-ын удирдлага, багш нар ажлын байрандаа бие дааж болон өөрийн сонголтоор, салбарын төлөвлөгөөт сургалтуудад 100 хувь хамрагдсан. Ажлын байр болон дотоодын сургалтыг 18 удаа, бүс аймгийн сургалтад 12 удаа, үндэсний хэмжээнд зохион байгуулсан 10 удаагийн сургалтуудад нийт 45 албан хаагч хамрагдсан байна. Англи хэлний “Pearson” хөтөлбөрийн сургалтад 2 багш, Үнэлгээний сургалтад 1 багш, Бага хурлын зөвлөгөөнд 2 багш, Бага ангийн багш нарын туршлага солилцох сургалтад 5 багш, Залуу багш нарын зөвлөгөөнд 5 багш хамрагдаж, 1073.0 мян төгрөгийг зарцуулсан байна.	100

27	багш нарыг шалгаруулах, харилцан туршлага солилцох боломжийг олгох.	2	Мэргэжлийн ур чадвар, арга зүйг төлөвшүүлсэн "Тэргүүний багш" шалгуур болзол гарган үнэлэж урамшуулах, арга туршлагыг түгээх	Мэргэжлийн ур чадвар арга зүйгээр амжилттай үнэлэгдсэн 4 багш, ажилтанг гүйцэтгэлд суурилсан үр дүнгээр урамшуулсан. Төсвийн шинэчлэлийн бодлого зорилтын хэрэгжүүлэхээр БШУЯ, БЕГ, Боловсролын үнэлгээний төвөөс хийсэн "Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээ"-нд хангалттай үнэлэгдсэн багшид 1595306 төгрөгийн урамшуулал олгосон. Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан багш нарын гүйцэтгэлийн үнэлгээнд 3-р түвшинд 2 багш, 4-р түвшинд 9 багш үнэлэгдсэн. 9,10 сарын гүйцэтгэлийн урамшууллыг 3-р түвшинд үнэлэгдсэн 2 багшид цалингийн 15 хувь, 4-р түвшинд үнэлэгдсэн 9 багшид цалингийн 10 хувиар мөнгөн урамшуулалыг олгосон. Багш Б.Лхамдулам, Б.Мөнхзаяа, жижүүр Д.Мөнгөнсар нарын ажлын үр бүтээлийг өндрөөр үнэлж "Яамны жуух бичиг"-ээр шагнасан.	100
28	1.2.4. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэх замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, "Хүүхдэд ээлтэй" сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	1	150 хүүхдийн ортой дотуур байрны барилгыг шинээр барих	150 хүүхдийн ортой 3.7 тэр бум төгрөгийн төсөвт өртөгтэй дотуур байрны барилгын ажил 75 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.	100
29		2	Цэцэрлэгийн барилгад их засвар хийх	Аймгийн төсвийн 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн барилгад их засвар хийгдсэн. Их засвараар барилгын гадна фасад, сантехник, барилгын дээвэр, цонх, цахилгааны мантажийг шинэчлэх ажил хийгдсэн.	100
30		3	ЕБС-ийн хичээлийн 1-р байранд их засвар хийх	Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж байгаа Сургууль, цэцэрлэг, дотуур байрны модон жорлонг халах ажлын хүрээнд тус сургууль дээр эрэгтэй 5, эмэгтэй 5, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1 нийт 11 суултуур, 8 угаалтуур бүхий дотор бие засах газар 175,0 сая төгрөгийн өртөгөөр хийгдэж байна.	70
31		4	ЕБС, цэцэрлэгийн цахим тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хатуу зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмж, тоглоом наадгайгаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	2023 онд 1.9 сая төгрөгийн өртөг бүхий 8 ширхэг сурагч ширээ, 800,0 мян төгрөгийн өртөг бүхий сургалтын хэрэглэгдэхүүнийг авсан. Мөн 4.1 сая төгрөгийн өртөг бүхий сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай бэлтгэсэн. УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ "Шинэ хөдөө-Боловсрол" төслийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 19 багшид зөөврийн компьютерыг олгосон. Мөн ЕБС-ийн нөхөн хангалтын зардлаас 11 багшид 32.9 сая төгрөгийн өртөг бүхий зөөврийн компьютер авахаар хүсэлтийг явуулсан байна.	70
32		5	ЕБС, цэцэрлэгийн гадна спорт талбай, тоглоомын талбайг засварлан тохижуулах	Цэцэрлэгийн гадна хүүхдийн тоглоомын талбайд 6 сая төгрөгийн өртөг бүхий 2ш сүүдрэвчийг авч байрлуулсан. Сурагчдын эцэг эхчүүдээс 1 хүүхэд 1 цемент аяныг зарлан эцэг эх, ажилчид хамтран явган хүний зам болон 10 машины зогсоолыг хийсэн. Булган аймгийн 2024 оны төсөвт 320 сая төгрөгийн өртөг бүхий ЕБС-ийн биеийн тамирын спорт талбайн ажил тусгагдсан.	100
<b>Боловсролын зорилтын дүн</b>					<b>93</b>
<b>1.2. Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, амьдралын салшгүй хэсэг болгож, иргэдийн нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцлийг бүрдүүлж, эрүүл мэндийг хамгаална.</b>					
33	1.3.1. Хүн амыг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр	1	Иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх орчин нөхцлийг сайжруулах	Булган аймгийн 2024 оны төсөвт 320 сая төгрөгийн өртөг бүхий ЕБС-ийн биеийн тамирын спорт талбайн ажил тусгагдсан. Мөн Монгол улсын 2024 оны төсөвт хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил тусгагдсан.	70

34	хичээллэх, эрүүл дадал хэвшилд сургах ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.	2	Бүх насны иргэдэд чиглэсэн бүжгийн спортыг хөгжүүлэх	Цэнгээнт бүжгийн багш Я.Оюунтуяаг урьж иргэдэд цэнгээнт бүжгийн румба, ёохор зэрэг 3 төрлийн бүжиг заалгасан. Бүжгийн сургалтад албан байгууллага, ААН-ээс 23 хүн хамрагдав.	70
35		3	Идэвхитэй хөдөлгөөнд суурилсан явган болон дугуйн аялал, алхалт, гүйлтээр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлж, спортын тэмцээн, уралдааныг тогтворжуулах	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдаж буй "Эрүүл хандлага-Эрүүл нийгэм" аяны хүрээнд зохион байгуулагдсан "Цаг гаргая" биеийн тамирын арга хэмжээгээр соёлын төв болон спорт зааланд өдөр бүр 06:30 цагаас өглөөний дасгал хөдөлгөөнийг хийж хэвшсэн. Албан байгууллагууд ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшсэн. Мөн ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын дунд явган аялалыг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 320 хүүхдийг хамруулсан.	100
36		4	Идэвхитэй дасгал хөдөлгөөнийг хэвшил болгон, иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх дадал хэвшилд уриалан, нийтийн биеийн тамир, спортыг дэмжин ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг урамшуулан дэмжиж, үйл ажиллагааг нь сурталчлан таниулна.	"Нийтийн биеийн тамир, спорт, эрүүл мэнд"-ийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг 18 ажил тусган боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өсвөрийн шатарчдын сумын аварга шалгаруулах тэмцээн, Дашинчилэн сумын "Волейбол"-ын аварга шалгаруулах тэмцээн, "Өвлийн өнгө" цасны баяр-2023 арга хэмжээ, "Хуйрнан шуугигч" үндэсний бөхийн хүүхдийн барилдааныг 5-6 нас, 7-8 нас, 8-9 нас гэсэн 3 насны ангилалаар, Сар шинийн баярт зориулсан хүчит бөхийн барилдаан, Монгол цэргийн баярын өдрийг тохиолдуулан "ДӨЛ" цэрэг спортын тэмцээн, "Ханьтайгаа хамтдаа" тэмцээн, "Татвар төлөгчдийн өдрүүд-2023" арга хэмжээний хүрээнд Волейболын тэмцээнийг тус тус зохион байгуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдаж буй "Эрүүл хандлага-Эрүүл нийгэм" аяны хүрээнд "Цаг гаргая" биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, Ахмадын дунд софт волейболын тэмцээн, ЕБС-ийн сурагчдын дунд явган аялал зохион байгуулсан. Хишиг-Өндөр суманд 2023 оны 04-р сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Урд бүсийн аварга шалгаруулах Волейболын тэмцээнд эрэгтэй, эмэгтэй 2 баг оролцлоо. "Дэлхийн Алтаргана" XV наадмын бэлтгэл ажил, "Буриад зон-өв соёл-2023" аяны хүрээнд зохион байгуулагдсан "Буриад дуу бүжиг"-ийн уралдаан 12 хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай оролцсон байна. Мөн Булган аймгийн Тэшиг суманд зохион байгуулагдсан Өсвөрийн бөхийн барилдаанд амжилттай оролцсон. Ахмадын баярт зориулсан Софт волейболын тэмцээн, Шатар, даамны тэмцээн, Малчдын дунд Волейболын тэмцээн, Караокены тэмцээн, ЕБС-ийн сурагчдын дунд Дэвжээ тэмцээн, "Налгар намар-Эрүүл алхалт" явган аялалыг зохион байгууллаа. Нийтийн биеийн тамир спортыг дэмжих арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 1200 гаруй иргэн хамрагдаж, 5,5 сая төгрөг зарцуулсан байна.	100
37		5	Спортын холбоодыг бодлогоор дэмжинэ	МСУХ-той хамтран Улсын баяр наадмын хурдан морины уралдааныг зохион байгуулсан. 2023 онд "Хар бух" шагайн харваан холбоог шинэчлэн байгуулж, холбооны даргаар Г.Ганбат сонгогдсон.	70



38		1	Үндэсний бөх, сур, шагайн харваа, мөсний шагай, мөсний сурын харвааг хөгжүүлэх	“Хуйрнан шуугигч” үндэсний бөхийн хүүхдийн барилдааныг 5-6 нас, 7-8 нас, 8-9 нас гэсэн 3 насны ангилалаар 60 гаруй хүүхэд оролцож амжилттай зохион байгуулсан. Сар шинийн баярт зориулсан хүчит бөхийн барилдааныг зохион байгуулж, 32 бөх барилдсан байна. “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулсан “ХУЙРНАН ШУУГИГЧ” хүүхдийн бөхийн барилдаан 6-7 нас, 8-9 насны ангилалаар, “Өсвөрийн үндэсний бөх”-ийн барилдаан 15-17 насны 120 гаруй хүүхдүүдийн дунд зохион байгуулагдсан. Мөн багуудын өдөрлөгөөр үндэсний бөхийн барилдаан зохион байгуулж, 96 бөх барилдсан байна. Сумын баяр наадмын сурын харваанд 20 гаруй харваач, шагайн харваанд 18 харваач, үндэсний бөхийн барилдаанд 64 бөх барилдсан байна. Тэмцээн уралдаанд давхардсан тоогоор 410 хүнийг хамруулсан	100
39	1.3.2. Үндэсний спорт болон уламжлалт тоглоом наадгай, олимпын төрлийн спортуудыг бодлогоор дэмжиж, тамирчдын амжилтыг ахиулах, олон улс, улс, бүсийн чанартай уралдаан, тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэх, олон улс, улсын чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргасан тамирчдыг урамшуулах ажлыг зохион байгуулна.	2	Өсвөрийн шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлэх. /волейбол, сагсан бөмбөг, жудо, хөл бөмбөг, цана, тэшүүр, хөнгөн атлетик, самбо бөх гэх мэт/	Булган аймгийн 2023 оны Өсвөр үеийн "Жүдо бөх"-ийн аварга шалгаруулах тэмцээнд 66 кг-ийн жинд 11а ангийн сурагч А.Батмэнд алтан медаль, 63 кг-ийн жинд 8в ангийн сурагч З.Энхцацрал алтан медаль, 81 кг-ийн жинд 11а ангийн сурагч А.Элбэгзаяа мөнгөн медаль, +70 кг-ийн жинд 11а ангийн сурагч Б.Мичидмаа мөнгөн медаль, 55 кг-ийн жинд 8в ангийн сурагч Г.Өсөхбаяр мөнгөн медаль, 54 кг-ийн жинд 6б ангийн сурагч Б.Батхүү мөнгөн медаль, 66 кг-ийн жинд 9б ангийн сурагч Б.Энэрэлт хүрэл медаль, 63 кг-ийн жинд 8а ангийн сурагч А.Эрдэнэтунгалаг хүрэл медаль, 55 кг-ийн жинд 8а ангийн сурагч Ц.Базаррагчаа хүрэл медаль, 46 кг-ийн жинд 7б ангийн сурагч М.Өлзий-Учрал хүрэл медаль, 63 кг-ийн жинд 5а ангийн сурагч Т.Мөнхсайхан хүрэл медаль тус тус хүртсэн байна. Монголын хүүхдийн спортын VII-р наадмын "САМБА БӨХ"-ийн анхан шатны "АЙМГИЙН АВАРГА" шалгаруулах тэмцээнд 71 кг жинд 11а ангийн сурагч А.Батмэнд мөнгөн медаль, 80 кг жинд 11а ангийн сурагч А.Элбэгзаяа хүрэл медаль, 59 кг жинд 8в ангийн сурагч З.Энхцацрал алтан медаль, 72 кг жинд 11а ангийн сурагч Б.Мичидмаа алтан медаль, 80 кг жинд 12а ангийн сурагч Б.Золжаргал алтан медаль тус тус хүртсэн. 2023 оны аймгийн аварга шалгаруулах 15-16 насны волейболын тэмцээнд Ж.Цогтбаатар багш, дасгалжуулагчтай баг тамирчид оролцож, эрэгтэйчүүдийн төрөлд багийн дүнгээр дэд байр эзэлж мөнгөн медаль хүртэж, 10а ангийн сурагч А.Бишрэлт шилдэг хамгаалагчаар шалгарсан.	100
40		3	Олон улс, улсын чанартай уралдаан тэмцээнд амжилт гаргасан тамирчдыг урамшуулах, тамирчдыг уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх.	Өсвөрийн шатарчдын сумын аварга шалгаруулах тэмцээн ЕБС-д 7, 9, 11 гэсэн насны ангилалаар эрэгтэй, эмэгтэй төрлөөр зохион байгуулагдаж, 25 хүүхэд оролцсон. Насны ангилал тус бүр эхний 2 байранд орсон сурагчдыг аймгийн аварга шалгаруулах “Цодгор хүү-2023” шатрын тэмцээнд оролцох батламжийг гардуулсан. “Дэлхийн Алтаргана” XV наадмын бэлтгэл ажил “Буриад зон-өв соёл-2023” аяны хүрээнд зохион байгуулагдсан “Буриад дуу бүжиг”-ийн уралдаанд 12 хүний бүрэлдэхүүнтэй баг амжилттай оролцсон байна. Хишиг-Өндөр суманд зохион байгуулагдсан Урд бүсийн аварга шалгаруулах Волейболын тэмцээнд эрэгтэй, эмэгтэй 2 баг оролцож эмэгтэй баг тамирчид 2-р байранд орсон амжилтыг үзүүлсэн. Булган аймгийн Тэшиг суманд зохион байгуулагдсан Өсвөрийн бөхийн барилдаанд Ж.Цогтбаатар дасгалжуулагчтай баг тамирчид амжилттай оролцсон. Булган аймаг зохион байгуулагдсан бүтээлийн	100

				үзэсгэлэнд технологийн багш Э.Дондог, ОУХЭХӨ-ийг тохиолдуулан Булган аймагт зохион байгуулагдсан 100 хүүхдийн тоглолтод 11-р ангийн сурагч Б.Энхжин нар тус тус оролцсон байна. Тэмцээн уралдаанд 42 хүн оролцож, тэмцээний уралдааны зардалд Засаг даргын нөөц хөрөнгөөс 937,500 төгрөгийг зарцуулсан байна.	
41	1.3.3. Өсвөр үе, хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, авьяас, ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, үндэсний болон өвөл, зуны спортын тэмцээнүүдийг сумын хэмжээнд зохион байгуулна.	1	Биеийн тамирын секц дугуйлангийн төрөл, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх	СӨБ олгох чиглэлээр уран уншлага, драм, зураг бүтээл, бүжгийн дугуйланг хичээллүүлж, нийт хүүхдийн 40%-ийг хамруулан сургаж байна. Эх хэл, байгалийн ухаан, техник технологи, гадаад хэл, урлаг спортын төрлөөр "Бичгийн жим", "Хүмүүн бичиг", "Залуу байгальч", "Залуу зохион бүтээгч", "Юмхнаар юм хийе", "Ноён бэрс", "Цэцгэн хуар", "Чихмэл тоглоом урлал", "Уран зангилаа", "Үндэсний болон жудо бөх", 11-18 хүртлэх нас насны ангилалд "Волейбол", "Си хэл", "Мэргэн мэтгэлцээний клуб" зэрэг 15 дугуйланд давхардсан тоогоор 302 хүүхэд хамрагдаж байна.	100
42		2	Өсвөр үе, хүүхэд, залуучуудын дунд өвөл, зуны анхан шатны тэмцээнүүдийг зохион байгуулах	Залуучуудын сумын аварга шалгаруулах "Волейболын тэмцээн", татвар төлөгчдийн өдөрт зориулсан "Волейболын тэмцээн", "Цаг гаргая" аяны хүрээнд "3х3 сагсан бөмбөг"-ийн тэмцээн, "Өвлийн өнгө - 2023" цасны баяр, ЕБС-ийн аварга шалгаруулах волейболын тэмцээнийг 7-12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулсан байна. Нийт 284 хүнийг хамруулж, 1.5 сая төгрөгийг зарцуулсан.	70
<b>Биеийн тамир, спортын зорилтын дүн</b>				<b>88</b>	
<b>1.4. Соёл, урлаг. Соёлын төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үндэсний өв уламжлалыг залгамжилж, орчин үеийн соёл урлагийн чиг хандлагатай хослуулан хөгжүүлнэ.</b>					
43	1.4.1. Анхдагч алдартан, гавьяатуудын дурсгалыг мөнхжүүлэх	1	Сум орон нутгаас төрөн гарсан Монгол улсын анхны алдарт гавъяат хөгжимчин Д.Түдэв хуурч, Төр нийгмийн зүтгэлтэн төрийн соёрхолт зохиолч С.Удвал, МУУГЗ Б.Ганхуяг, МУГЖ Б.Баасанжав, Д.Ширрмэнтуяа нарын уран бүтээлийг сурталчлан таниулах сургалт зохион байгуулах	Нутгийн яруу найрагч МЗЭ-ийн гишүүн Алтан гадас, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Б.Найдандоржийн "Алтан нутаг" дууны чөлөнг зохион байгуулав. Чөлөнгөд 5 байгууллага оролцсоноос ЭМТ-ийн хамт олон шалгарч зохиогчийн үр хүүхдүүд 500.0 төг-р шагнаж урамшуулав. Цогт тайжийн цагаан байшинд болсон "Сэтгэшгүй чандмань" яруу найргын баярт зориулж "Цогтын цэргүүд" бүжгийн урлагийн номерын тоглолт үзүүлж, контент хийв.	70
44	1.4.2. Уламжлалт өв соёл, зан заншлыг хойч үедээ өвлүүлэх, орчин үеийн соёл урлагийг түгээн дэлгэрүүлнэ.	1	Монголын үндэсний өв уламжлал, уран нугралтыг хөгжүүлэх	Уран нугаралтын дугуйланд 5 хүүхдийг сургаж, уран нугаралтын техникийг эзэмшсэн. Баяр наадмын тоглолтод оролцсон.	100
45		2	Морин Хуур, Уртын дуу хөтөлбөрийг үргэлжлүүлэн хөгжүүлнэ.	Уртын дуу, Морин хуур, дуу хөгжмийн сургалтыг насанд хүрэгчид болон сурагчдын дунд хичээллүүлж байна. Морин хуур, уртын дууны анхан шатны сургалтад насанд хүрэгчид 3, хүүхэд 6 хамрагдаж, сургалтад хамрагдагсадын тоо урд оныхоос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100

46		3	Цэнгээнт бүжиг, арозбекийн дасгалыг хөгжүүлэх	Цэнгээнт бүжгийн багш Я.Оюунтуяаг урьж иргэдэд цэнгээнт бүжгийн румба, ёохор зэрэг 3 төрлийн бүжиг заалгасан. Бүжгийн сургалтад албан байгууллага, ААН- ээс 23 хүн хамрагдсан. Соёлын төвийн бүжгийн дугуйланд 96 хүүхэд 7 хоногт 2 ээлжээр хичээллэж байна.	100
47		4	Дуу хөгжим, бүжгийн дугуйланг хичээллүүлэх	Соёлын төвд дуу, үндэсний хөгжим, бүжгийн дугуйлангууд хичээллэж байна. Дугуйланд давхардсан тоогоор 114 хүүхэд, 6 насанд хүрэгчид суралцаж байна.	100
48	1.4.3. Соёлын төвийн техник хэрэгсэл, материаллаг баазыг сайжруулна.	1	Соёлын төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангах	Тайзны болон ерөөнүүдийн хөшгийг 20.7 сая төгрөгийн хөрөнгөөр шинэчилсэн. Мөн 712 мян төгрөгөөр утастай болон зайны микрофон 4 ширхэгийг худалдан авсан. Номын санд шаардлагатай олон үйлдэлт өнгөт принтер 1ш 719000, уншигчдын 6 ширээ сандал 12ш 1,6 сая нийт 2,4 сая төгрөгийн санхүүжилтээр авсан.	100
49	1.4.4. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх, нэгдсэн сүлжээнд оруулах.	2	Жуулчдад урлагийн тоглолт зохион байгуулах	Цогт тайжийн цагаан байшинд болсон “Сэтгэшгүй чандмань” яруу найргийн баярт зориулж “Цогтын цэргүүд” бүжгийн урлагийн номерын тоглолт үзүүлж, контент хийв.	70
50		3	Түүх соёлын дурсгалт газруудаар аялал зохион байгуулах	Ерөнхий боловсролын сургуультай хамтран 8-12 дугаар ангийн сурагчдын дунд явган аялалыг зохион байгуулж, 100 гаруй сурагчдыг хамруулсан.	100
51		4	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд оруулах.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар Соёлын яамны дэд сайд Батбаяр, урлаг уран бүтээл хариуцсан хэлтсийн дарга Б.Сэргэлэн, Чингис хаан музейн захирал Чулуун, Соёлын өвийн дарга Энхбат, Аймгийн СУГ-ын дарга Г.Алдармөнх, Музейн дарга Т.Бэхтөр нарын 10 хүний бүрэлдхүүнтэй ажлын хэсэг Хар бухын балгас, Цогт тайжийн балгастай танилцах ажил зохион байгуулагдсан. Үүний дагуу БОАЖЯ-с 25 хүний бүрэлдхүүнтэй аялал жуулчлалын маршрут гаргах ажлын хэсгийг суманд ажиллаж, маршрут гаргах ажил хийгдсэн.	100
<b>Соёл урлагийн зорилтын дүн</b>					<b>93</b>
<b>1.5. Хөдөлмөр эрхлэлт. Орон нутгийн бизнес эрхлэгчид, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинээр бий болсон ажлын байрыг тогтвортой хадгалж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.</b>					
52	1.5.1. Сумын хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн “Мэргэжилтэй ажилтан бэлтгэх” ажлыг төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоонд тулгуурлан зохион байгуулна.	1	Сумын хөдөлмөрийн зах зээл, мэргэжил эзэмшсэн иргэдийн судалгааг нарийвчлан гаргах	Сумын хөдөлмөрийн зах зээлийн нарийвчилсан судалгааг гаргасан. Суманд хөдөлмөрийн насны 1192 иргэн байгаагаас, төрийн албанд 168, хувийн хэвшилд 149, мал аж ахуйн салбарт 859 иргэн ажиллаж байна.	100
53		2	Сумын хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэд болон 12 анги төгсөгчдийн хэрэгцээ, ур чадвар, хүсэл сонирхлыг харгалзан	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Эндээ-Хөгжил ТББ-тай хамтран тогоочийн 14 хоногийн сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 25 хүн хамрагдаж, үнэмлэх болон чадамжийн гэрчилгээ авсан.	100

			мэргэжил олгох сургалтанд хамруулна.		
54		3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр байгууллага, аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллаж, "Бүтээмжийн хөдөлгөөн" өрнүүлэх шинэ санал, санаачлагыг дэмжих.	Албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн дунд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн" сарын аянг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан, 4 зорилтын хүрээнд 21 ажлыг төлөвлөн ажилласан. Албан байгууллага, ААН-үүдэд цалин хөлсний үзлэг шалгалтыг нэг удаа зохион байгуулсан. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын явцтай танилцах ажлыг улирал бүр зохион байгуулсан. ЕБС-ийн жишиг гал тогоог түшиглэн гал тогоо бүхий газрууд болон цайны газруудын тогооч нарын туршлага солилцох ажлыг зохион байгуулсан. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулиар сургалтыг 1 удаа зохион байгуулан 46 иргэнийг хамруулсан. Мөн байгууллага, ААН бүр ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшсэн.	100
55	1.5.2. Байнгын, түр, улирлын ажлын байрыг бүртгэлжүүлэх ажлыг төр, хувийн хэвшил, ажил олгогч, иргэдтэй хамтран чанаржуулах, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, байнгын, түр, улирлын ажлын байраар хангана.	1	Байнгын, түр, улирлын ажлын байрыг бүртгэлжүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулж, иргэдийг байнгын, түр, улирлын ажлын байраар хангана.	2023 оны 11 сарын байдлаар ажил зуучлах үйлчилгээнд 50 иргэн хамрагдсан. Байнгын ажлын байранд 38, улирлын ажлын байранд 1, түр ажлын байранд 11 иргэнийг зуучилж, хэрэгжилт 78%-тай байна. Шинэ ажлын байр 41 үүнээс байнгын ажлын байр 26, түр ажлын байр 15-ыг тус тус програмд шивсэн байна. Нийтийг хамарсан ажлын хүрээнд "Сэг зэм устгах", "Мод тарих талбайг хашаажуулах" ажилд 21 иргэнийг хамруулж 8.4 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна. Мөн сумын төвийн засмал зам цэвэрлэх ажилд 13 иргэнийг ажиллуулж, 5,2 сая төгрөгийн урамшууллыг олгосон.	100
56	1.5.3. Өрхийн үйлдвэрлэл болон хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхол, боломжтой иргэдийг дэмжих, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, ажлын байранд зуучлах замаар 400-аас доошгүй ажлын байр бий болгоно.	1	Ажилгүй, ажил олоход хүндрэлтэй иргэд, хоршоо болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин төсөл хөтөлбөрт хамруулж шаардалгатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ.	ХЭДС-н төсөл хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг хамруулж, 7 сая төгрөгийн төсөл хөтөлбөрт хамрагдсан. 2023 оны 03-р сарын 23-ны өдрийн сумын ИТХ-ын ээлжит XIII хурлаар Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох салбар, чиглэл, зээлийн доод хэмжээ, хөнгөлөлттэй зээлийн тов тогтоолгосон. 2023 оны 05-р сард нийт 4 иргэнд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 106,1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.	100
57		2	Жил бүр орлого багатай 3-аас доошгүй малчин өрхийг малжуулах ажлыг зохион байгуулна.	Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан "Малжуулах" төсөлд 2 иргэн хамрагдаж, тус бүр 5 сая төгрөгийн санхүүжилт авсан. Мөн иргэн А.Сүхбаатар нь 2 өрхийг тус бүр 5 сая төгрөгөөр малжуулсан.	100
<b>Хөдөлмөр эрхлэлтийн зорилтын дүн</b>				<b>100</b>	

1.6. Нийгмийн хамгаалал, халамж. Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах, иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгоход бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлнэ.					
58	1.6.1. Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг нэмэгдүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах.	1	Нийгмийн зорилтод бүлгийн иргэдийг нийгмийн халамж, үйлчилгээнд бүрэн хамруулах	Сумын хэмжээнд 104 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. ХЭДС-н төсөл хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг хамруулж, 7 сая төгрөгийн төсөл хөтөлбөрт хамрагдсан. Халамжийн үйлчилгээнд нийтдээ 15 иргэн хамрагдсанаас 3 иргэн рашаан сувилалд, түлээний хөнгөлөлтөд 4 иргэн, бусад хөнгөлөлт үйлчилгээнд 8 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан. Төрийн байгууллагад нийт хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн хөдөлмөр эрхэлж байна.	100
59		2	Нийгмийн зорилтод бүлгийн иргэдийг байнгын болон түр, улирлын ажлын байраар хангах, зээл тусламжинд хамруулах замаар өрхийн орлого, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх	Амьжиргааг нь дэмжихээр "Зөв-20" гэр бүлийг сонгосон. Байнгын ажлын байртай 10 иргэн, улирлын ажлын байртай 5 иргэн, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа 4 иргэн байна. "Хүрч үйлчилье" аяны хүрээнд өрхөөр зочилж нөхцөл байдлын үнэлгээ хийсэн. 2023 онд 1 өрх хүмүүнлэгийн тусламжид, улаан загалмайн тусламжид 2 өрх тус тус хамрагдсан. Мөн "Хайр түгээе бууз" аяны хүрээнд зорилтот өрхийн 3 айлд тус бүр 200ш бууз өгсөн. Эрсдэлт нөхцөлд амьдарч буй 3 айлд тусламжийн хүнс болон ахуйн хэрэглээний зүйлсийг өгсөн байна.	100

60	1.6.2. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хүчирхийлэлд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтийн оролцоонд тулгуурлан хийх, хариу үйлчилгээний арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулах, хүүхдэд ээлтэй орон нутгийг бий болгоно.	1 Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, Хүүхэд хамгааллыг дэмжих, Эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх гэсэн 4 чиглэлийн хүрээнд 20 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. Хамтарсан баг нь 2023 онд хийгдэх ажлын төлөвлөгөө, нууцын гэрээ, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлагад хариу арга хэмжээ авах ажлын дагуу хамтарсан багийн хурлыг одоогийн байдлаар 6 удаа зохион байгуулсан байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй 16 хүүхэд байна. Үүнээс 13 буюу 81 хувь нь эрэгтэй, 3 буюу 19 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага энэ онд 5 ирсэнийг цагдаагийн хэсэгтэй хамтран тухай бүрд арга хэмжээг авч ажилласан. 108 утсанд 4 дуудлага ирж, холбогдох арга хэмжээг авч, кейсыг хааж, НАМС программд шивсэн байна. 8-12-р ангийн 8 бүлгийн 131 сурагчдад “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн ойлголт” сэдвээр сургалтыг 2023.04.20-ны өдөр 1 удаа зохион байгууллаа. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг сумын фэйсбүүк (Булган Аймаг Дашинчилэн Сум) хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж ажиллаж байна. ЕБС-ийн 8-12-р ангийн сурагчдад 1 удаа “Үе тэнгийн дээрэлхэлт”, “Утаат болон электрон тамхины хор уршиг”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдал”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт”, Мэргэжил сонголтын сургалтыг зохион байгуулсан. “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх”, “Гэр бүлийн харилцаа”, “Гэр бүлийн санхүү” Угийн бичиг-Удмын хэлхээ” сургалтыг 20 гаруй албан хаагч залуучууд болон ЕБС-ийн хүүхдүүдийн 21 эцэг эхчүүдийн дунд зохион байгуулсан. 9-12-р ангийн сурагчдын дунд “Дэвжээ” тэмцээн зохион байгуулсан. Сургалт нөлөөллийн ажилд давхардсан тоогоор нийт 450 гаруй иргэнийг хамруулсан.	100
61		2 Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хүчирхийлэлд өртөх эрсдэлийг илрүүлэх тандалт судалгааг нийт иргэдийн дунд явуулж, судалгаанд үндэслэн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хариу үйлчилгээг зохион байгуулах	Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй 2-18 насны 16 хүүхэд, үүнээс 3 нь эмэгтэй, 13 нь эрэгтэй хүүхэд байна гэсэн судалгаа гарсан. Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн талаар сургалтыг ЕБС-ийн 8-12-р ангийн 8 бүлгийн 131 сурагчдад 1 удаа зохион байгуулсан. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн хараа хяналтыг сайжруулах үүднээс сар болгон гэрийн эргэлт уулзалтыг хийж байна. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага цагдаагийн газраас 1, 108 утсанд хүүхэдтэй холбоотой 4 дуудлага бүртгэгдэж, холбогдох арга хэмжээг авч, хувийн хэргийг хааж, НАМС программ руу шивсэн. Булган аймгийн өсвөр үеийн кабинетийн бага эмч Ц.Булгантамир ЕБС-ийн 5-12 ангийн сурагчдын дунд "Охид хөвгүүдийн эрүүл мэнд", "Өсвөр үеийнхний нөхөн үржихүй", "Хүчирхийлэл ба түүний үр дагавар" гэх мэт сэдвээр сургалт зохион байгуулж, нийт 322 хүүхэд хамрагдсан. Зөв хүн байя" сарын	100

			аяны хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурагчдад хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн 9-12-р ангийн сурагчдын дунд "Дэвжээ" тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд оролцсон байгуудад тусгайлан бэлдсэн (Архи түүний хор уршиг, Утаат тамхи түүний хор уршиг, Үе энгийн дээрэлхэлт, Гэр бүлийн хүчирхийлэл, Электрон тамхи, Цахим хэрэглээ) сэдвийг өгч, тухайн сэдвүүдийн хүрээнд болсон. Тэмцээнд 7 бүлгийн 42 хүүхэд оролцсон.		
62		3	Хүүхдэд ээлттэй орон нутгийг бий болгох ажлыг эхлүүлэх	ЕБС-ийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл, сумын хамтарсан баг, ЕБС-ийн захиргаа хамтран ЕБС-ийн сурагчдын эцэг эхийн зөвлөгөөнийг зохион байгуулсан. Зөвлөгөөнд 25 бүлгийн 71 эцэг, эх, асран хамгаалагчид хамрагдсан. ЕБС-ийн "Хүүхдийн хөгжлийг дэмжих төв"-ийг шинээр байгуулан, засвар тохижилтын ажилд 9,3 сая төгрөгийг зарцуулсан. Мөн сумын "Хүүхэд хөгжлийн төв"-ийг шинээр байгуулж, тохижилтын ажилд ОНХС-аас 10 сая төгрөгийг зарцуулсан. "Хүүхэд сонсох өдөр"-ийг 1 удаа зохион байгуулж, 5-11 дүгээр ангийн 14 сурагчдын төлөөллийг хамруулсан. Сурагчид "Найз байя", "Хайр-Хариуцлага", "Ногоон байгаль", "Эерэг хандлага-Эрүүл залуу үе", "Сумын хөгжилд бидний оролцоо" сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэн, "Хүүхэд бүр нэг мод тарья", "Цаас бол цэцэг биш" уриалгыг гаргасан байна. Аймгийн ИТХ ГХУССАЗЗөвлөлөөс ЕБС-ийн сурагчид хүссэн үедээ бүх операторуудын дугаар луу үнэ төлбөргүй ярих боломжтой "Итгэлтэй утас"-г сургуульд байршуулсан.	100
63	1.6.3. Хүн амын бүлгүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хөгжил хамгааллыг сайжруулах, үйл ажиллагааг нь дэмжих хөгжлийн төвийг бий болгох, орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах	1	Нийгмийн бүлгүүдэд зориулсан чөлөөт цагаа өнгөрөөх, сурч хөгжих, нөлөөллийн ажлыг зохион явуулах "Хөгжлийн төв" байгуулах	ЕБС-ийн "Хүүхдийн хөгжлийг дэмжих төв"-ийг шинээр байгуулан, засвар тохижилтын ажилд 9,3 сая төгрөгийг зарцуулсан. Мөн сумын "Хүүхэд хөгжлийн төв"-ийг шинээр байгуулж, тохижилтын ажилд ОНХС-аас 10 сая төгрөгийг зарцуулсан.	100
64		2	Нийгмийн бүлгүүдийн нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх	Ахмадын дуун цэнгүүнийг сар бүрийн 10-ны өдөр зохион байгуулж, ахмадууд идэвхитэй хамрагдаж, дуу дуулан, нийтийн бүжиг бүжиглэж хэвшсэн. "Хүүхэд сонсох өдөр"-ийг 1 удаа зохион байгуулж, 5-11 дүгээр ангийн 14 сурагчдын төлөөллийг хамруулсан. Сурагчид "Найз байя", "Хайр-Хариуцлага", "Ногоон байгаль", "Эерэг хандлага-Эрүүл залуу үе", "Сумын хөгжилд бидний оролцоо" сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэн, "Хүүхэд бүр нэг мод тарья", "Цаас бол цэцэг биш" уриалгыг гаргасан байна. "Жендэрийн тэгш байдал ба хэвшмэл ойлголт" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 15 эрэгтэй, 15 эмэгтэй төлөөлөл хамрагдсан.	100
65		3	Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах	"Жендэрийн тэгш байдал ба хэвшмэл ойлголт" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 15 эрэгтэй, 15 эмэгтэй төлөөлөл хамрагдсан. Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөрийн хүрээнд Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулсан. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг	100

				хамгаалах өдрийг тохиолдуулан “Бүсгүйчүүд” тэмцээнийг зохион байгуулж, 26 иргэн хамрагдсан. ЭМТ, ЕБС-тай хамтран "Охид арга хэмжээ"-г зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Хүрч болохгүй 3 цэг” сэдэвт сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, чөлөөт ярилцлагыг зохион байгуулсан	
66	1.6.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах, хөгжих орчинг шат шатанд бүрдүүлэх.	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг нарийвчлан гаргаж, суралцах орчин нөхцөлийг бүрдүүлж, багш нарыг мэргэшүүлэх	Сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 5 хүүхэд сурч хүмүүжиж байна. Үүнээс хөнгөн хэлбэрийн 2, хөдөлгөөний саажилттай 2, аутизмттай 1 хүүхэд байна. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцах" сургалтад СӨБ-ын 6 багшийг хамруулсан. ХБ-тэй хүүхэдтэй ажиллаж буй 6 багш, туслах багшид шинээр хэрэгжиж буй хуулийн заалтын дагуу 10 хувийн цалингийн нэмэгдлийг сар бүр олгож байна. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдтай ажиллах арга зүйн сургалтад дахин 2 багшийг хамруулахаар төлөвлөөд байна.	100
67		2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх	Цэцэрлэгийн бэлтгэл ангийг төгсөөд дараагийн шатны боловсролд хамрагдах боломжгүй аутизмын хам шинжтэй 7 настай 1 хүүхдийг улиралд 1 удаа цэцэрлэгийн орчинд авчран хүүхдүүдтэй тоглуулах, сэтгэл зүйг засах, эцэг эхэд нь мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхэд СӨБ-ийн боловсрол эзэмшиж байна.	100
<b>Нийгмийн хамгаалал, халамжийн зорилтын дүн:</b>				<b>100</b>	
<b>ХҮНИЙ ХӨГЖИЛ БҮЛГИЙН ДҮН</b>				<b>95</b>	
<b>ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>					
<b>2.1. Эдийн засгийн тогтвортой хөгжил. Экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай, иргэдийн амьжиргааны түвшин өндөр, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий тэргүүлэгч аймгийн нэг болно.</b>					
68	2.1.1. Эдийн засгийн хөгжлийн 2021-2024 оны үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.	1	Бизнесийн таатай орчинг бүрдүүлэн үйлдвэрлэлийг хөгжүүлж ДНБ-ийг жил бүр нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.	2023 оны гүйцэтгэлээр сумын ДНБ 17,9 тэр бумд хүрч, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5.8 сая төгрөг болсон байна.	100
69	2.1.2. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ	1	Албан байгууллага, ААН, иргэдийг дотоодын худалдан авалт хийх талаар уриалга гаргах	Орон нутгийн бизнес эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагаас 3-р улирлын байдлаар төсвийн 6 байгууллага 74,8 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Орон нутагтаа үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхэлдэг ААН, иргэдийг дэмжиж ОНХСангаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд иргэн Ц.Баясгалангаар гэрэлтүүлгийн хэмжээг нэмэгдүүлэх, засвар арчилгаа хийх ажлыг 19.3 сая төгрөгөөр, иргэн Ц.Пүрэвзэвгээр Хараат багийн төвийг шинээр барих ажлыг 19 сая төгрөгөөр, иргэн Ч.Ганхуягаар Хараат багийн төвийг хашаажуулах ажлыг 8 сая төгрөгөөр, иргэн Д.Баттулгаар төрийн өмчийн	100



				барилга байгууламжийг засварлах ажлыг 10 сая төгрөгөөр тус тус гүйцэтгүүлсэн байна.	
70		2	Дотоодын бараа бүтээгдэхүүнийг сурталчлах ажлыг зохион байгуулах, зах зээлд борлуулахад дэмжлэг үзүүлэх	Цагаан сар үзэсгэлэн худалдаа-2023 арга хэмжээ 2023 оны 02-р сарын 15-ны өдөр Дүнжингарав худалдааны төвд зохион байгуулагдлаа. Үзэсгэлэн худалдаанд 1 байгууллага, 3 ААН, 3 хоршоо, 1 иргэн тус тус бүтээгдэхүүн үйлдвэрлэлээрээ оролцож нийт 5,6 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. Улаанбаатар хотноо зохион байгуулдсан AIRAGDAY арга хэмжээнд сумаас 5 иргэний бүрэлдэхүүнтэй оролцсон. Сумын брэнд бүтээгдэхүүн болох Соба гурил, Соба будааг борлуулж, 3,1 сая төгрөгийн борлуулалтыг хийсэн.	100
71	2.1.3. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.	1	Татвар төлөгчийг бүртгэх, тайлан хүлээн авах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, сургалт, сурталчилгаа хийх үйлчилгээг татвар төлөгчийн сегментийн ангилалд нийцүүлэн чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх	АТХ-ийн даргын баталсан удирдамжын дагуу хийгдсэн НӨАТ, онцгой албан татварын тэмдэгтийн тухай хуулиудын хэрэгжилтэд хяналт тавин 2 удаа тамгын газар болон цагдаагийн албан хаагч нартай хамтран хяналт шалгалт хийгдсэн. Цахим төлбөрийн баримт болон татварын тайлангаар нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн босго давсан 1 татвар төлөгчийг шинээр НӨАТ суутган төлөгчөөр бүртгэн, босго хүрээгүй 2 татвар төлөгчийн хасалт хийсэн. ХХОАТ, ААНОАТ-ын НӨАТУС, Галт зэвсгийн албан татварын тухай хууль, АТБӨЯХАТ зэрэг хуулиудаар цахим болон танхимын сургалтыг 17 удаа хийж, давхардсан тоогоор 233 иргэнийг хамруулсан байна. Татвар төлөгчдийн өдрүүдэд арга хэмжээний дагуу хэлтсээс зохион байгуулсан цахим сургалтад 9 ААН хамруулсан. Сургуулийн сурагчид 24, цэцэрлэгийн 13 хүүхдүүдэд танхимаар сургалт хийсэн.	100
72		2	НӨАТ-ын хуулийн дагуу цахим төлбөрийн баримтыг бүрэн нэвтрүүлж, баримт олголтыг татвар төлөгч бүрт хэрэгжүүлэн татварын бааз суурийг нэмэгдүүлснээр төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх	Сумын хэмжээнд цахим төлбөрийн баримтыг бүрэн нэвтрүүлсэн. ААН бүр баримтыг олгож хэвшсэн. 2023 оны 10 дугаар сарын байдлаар 317,2 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 271,2 сая төгрөгийн оруулан төсвийн орлогын төлөвлөгөө 85.4 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 оны 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр төсвийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелэхээр байна.	100
73	2.1.4. Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, төсвийн зардлын ил тод байдлыг хангана.	1	Төсөв, санхүүгийн цахим системийг үе шаттай нэвтрүүлж, ил тод байдлыг ханган ажиллах	Төсвийн 6 байгууллагын 600 мэдээлэл оруулахаас 586 мэдээ хугацаандаа 14 мэдээ хугацаа хоцроож оруулсан байна. Хугацаанд нь мэдээлэл байршуулалт 97 хувьтай байна.	100

Эдийн засгийн тогтвортой хөгжил зорилтын дүн				100
<b>2.2. Хүнс, хөдөө аж ахуй: Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг байгальд ээлтэй, уур амьчгалын өөрчлөлтөнд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй сумын эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.</b>				
74	2.2.1. "Шинэ хөдөө-Булган" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	1	Чацаргана хөтөлбөрийн хүрээнд тариалсан 10 га талбайд нөхөн сэргээлтийг хийж, хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах	70
75		2	Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх	100
76		3	ЖДҮ эрхлэгч, эрхлэх сонирхолтой иргэдэд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг нийлүүлж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	100
77		4	Үржлийн нэгжийн үйл ажиллагааг жишиг түвшинд хүргэх	100
78	2.2.2. Сумын бэлчээрийн даацад тохируулах мал аж ахуйн эрхлэлтийг дэмжих, өндөр ашиг шимт малын нийт	1	Мал аж ахуй эрхлэлтийг дэмжиж нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлж өндөр ашиг шимтэй малыг өсгөх	100

79	сүрэгт эзлэх хувийг нэмэгдүүлж, малын чанар ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж малчдын орлогыг өсгөнө.	2	Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжих	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор хоршоо хөгжүүлэх сангаас "Бяцхан дэл" хоршоо 3.Болормаа, Лах багийн иргэн Б.Батдэлгэр нарыг нийт 70 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлд хамруулсан. Бяцхан дэл хоршоо, Б.Батдэлгэр нар нь буган халиун үүлдэрийн 5 үнээ, алатау үүлдэрийн 4 үнээг тус тус худалдан авсан. Төслийг хэрэгжилтэд 1 удаа хяналт тавьж ажилласан.	100
80		1	Уст цэгийн хайгуул судалгаа хийж, усан хангамж дутагдалтай бэлчээрт инженерийн хийцтэй худаг гаргаж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	"Дашинчилэн сумын хүн амын ус хангамжийн эрэл хайгуулын ажил"-ын тендер зарлагдаж, гүйцэтгэгчээр "Хужирт сэртэн" ХХК шалгарсан. "Хужирт сэртэн" ХХК нь 7 цооног өрөмдөх ажлыг хийж, 7 цооног болон хуучин 7 худагийн усны дээжийг шинжилгээнд хамруулсан. Хүн амын ус хангамжид тохирч буй 4 цооногийг хүлээн авсан. Аймгийн байгаль хамгаалах сангийн 27 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хараат багийн "Дунд харын өвөр"-д инженерийн хийцтэй 1 худаг шинээр ашиглалтад оруулсан.	100
81	2.2.3. Бэлчээр, хадлангийн талбайг зохистой ашиглах, тариалангийн зориулалтаар эзэмшүүлсэн талбайг бүрэн эргэлтэнд оруулах, нөхөн сэргээх, уст цэгийн хайгуул судалгаа хийж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.	2	Орон нутгийн нөөц бүрдүүлэх зорилгоор ЗДТГ-ын эзэмшлийн хадлангийн талбай, хадлангийн техник, тоног төхөөрөмжтэй болох	Тус сумын Эрээн ухаад 1200 га талбайд байгалийн хадлан бэлтгэх хүсэлтэй 36 иргэний өргөдлийг хүлээн авч, ажлын хэсэг хуралдан 26 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн. 2023 онд 10 хадлангийн салаа гарч, нийт 13 трактор, 2 боогч, хадлангийн техник хэрэгсэл ашиглан сум орон нутгийн өвсний нөөцийг бүрдүүлж байна.	100
82		3	Бэлчээрийн даац багтаамжид нийцүүлж, малын тоо толгойг зохистой хэмжээнд хүргэх	Сумын 206062 га талбайг бэлчээрийн талбай эзэлдэг. Тус талбайд хонин толгойд шилжүүлснээр 147187 толгой мал байх ёстойгоос одоогийн байдлаар 416270 толгой мал байгаа ба бэлчээрийн даац 2,8 дахин хэтэрсэн байна. Малчдад бэлчээрийн даац хэтэрсэнтэй холбогдуулан, малыг зохистой хэмжээгээр эдийн засгийн эргэлтэд оруулах, чанартай мал өсгөх талаарх хэвлэмэл хуудас 200 ширхэгийг бэлтгэн, хүргэсэн. Бэлчээрийн даацыг бууруулах ажлын хүрээнд бэлчээр ашиглалтыг хариуцлагуулах журмыг боловсруулан батлуулж, захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Журмын хэрэгжилтийг сумын ИТХ-аар хэлэлцүүлсэн. Журмын хэрэгжилт 81.4 хувийн биелэлттэй байна. 2023 оны 10 дугаар сарын байдлаар зах зээлд амьдаар адуу-65, үхэр-32, хонь-3370, ямаа-1160, нийт 4627 толгой амьд мал буюу 89538 кг махыг эдийн засгийн эргэлтэд оруулсан.	100
83		4	Бэлчээрийн ургамалд хор хөнөөл учруулж байгаа хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг үргэлжлүүлэх	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг Улсын төсвийн 10,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хараат багт 2000 га, Лах багт 3000 га, Доргонт багт 2000 га, нийт 7000 га талбайд хийсэн.	100
84	2.2.4. Малын гоц халдварт өвчний тандалт сэргийлэлтийг	1	Мал эмнэлгийн арга хэмжээг тархвар зүйг үндэслэн төлөвлөх	Халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчний сүүлийн 24 жилийн судалгааг гарган баяжилтыг хийсэн. Судалгаанд үндэслэн мал эмнэлгийн халдварт өвчний төлөвлөлтийг хийн ажиллаж байна.	100

85	сайжруулж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллана.	2	Лаборатори шинжилгээнд хамрагдах мал сүргийг бүрэн хамруулах	Архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх лабораторийн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тус суманд бог малын хээлтүүлэгч 808 толгой малыг бруцеллэз өвчний шинжилгээнд бүрэн хамруулсан. Лабораторийн 2023 оны 23-6216 дугаартай дүгнэлтээр 1 хуц эерэг дүн гарсанг арга хэмжээ авч, устгалд оруулсан.	100
86		3	Малчид иргэдэд сургалт сурталчилгааг зохион байгуулах, гарын авлага боршур бэлтгэн тараах	2023 оны 03 сард аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас "Хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтнүүдийн нэгдсэн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, тус зөвлөгөөнд хөдөө аж ахуй, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд хамрагдаж, хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, салбар дундын уялдааг хангах чиглэлээр санал солилцсон. 2023 оны 03-р сарын 07-ны өдөр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан "Төлчин эмэгтэйчүүд" чуулга уулзалтад 30 малчин эмэгтэйг оролцуулж, хөтөлбөрийн дагуу "Мал аж ахуй эрхлэх арга барил боловсронгуй болгох, шинэ мэдлэг, техник, технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаанд дэвшил гарах талаар мэдлэг олгох" сургалтуудад хамруулж, малчин эмэгтэйчүүдийн мал маллах арга ухааны талаар санал бодол, туршлага солилцох арга хэмжээнд оролцуулсан. Мөн чуулга уулзалтын үеэр тус сумаас 12 малчин эмэгтэй шагнагдсан байна. Өндөр ашиг шимт малыг өсгөх, малын эрүүл мэндийг хамгаалах, малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий "Малчдын зөвлөгөөн 2023"-ыг зохион байгуулж, нийт 130 малчны төлөөллийг хамруулсан. Малчдын зөвлөгөөний хүрээнд лектор Чилаг урьж "Амьдралын үнэ цэнэ" сэдэвт сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. Малын үүлдэр угсаа сайжруулах талаар зөвлөмжийг 105 малчинд, малжуулах төсөл бичих талаар сургалтыг 12 иргэнд, малын генетик нөөцийн тухай хууль болон бусад мэдээ мэдээллийг 27 иргэнд биечлэн өгч ажилласан байна.	70
87	2.2.5. Мал сүргийг хамгаалах, халдварт өвчний гаралтыг бууруулах ажлыг зохион байгуулна.	1	Шаардлагатай мал сүргийг дархлаажуулалтанд бүрэн хамуулах	Тус суманд 2023 онд мал эмнэлгийн төлөвлөгөөт болон яаралтай дархлаажуулалтад Бог малын мялзан 154928, Шүлхий 13309, Галзуу 1993, Боом 8922, Бруцеллэз 63909, Дотрын халдварт хордлого 93502, Шөвөг яр 920, давхардсан тоогоор нийт 337483 толгой малыг дархлаажуулалтад бүрэн хамруулж ажилласан байна.	100
88		2	Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд төлөвлөлт, гүйцэтгэлийг оруулах	2023 оны мал эмнэлгийн арга хэмжээний хүрээнд 8 нэр төрлийн дархлаажуулалтын төлөвлөгөө, шимэгчтгэх өвчний төлөвлөгөө болон гүйцэтгэлийг цахим системд 100 хувь оруулсан. Мөн цахим гэрчилгээг хянан баталгаажуулж ажилласан.	100
89	2.2.6. Мал эмнэлгийн нэгжүүдийн чадавхийг сайжруулах, хүний нөөцийг бэхжүүлэх,	1	Шинээр төгссөн болон орон нутагт ажиллаж, амьдарч байгаа залуу малын эмч нарыг дэмжих	Тус суманд шинээр төгсөж ирсэн 1 малын эмчийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг хүлээн авч малын эмчийн итгэмжлэлийн сургалтанд хамруулж 2024 оноос эхлэн гэрээ байгуулан ажиллахаар болсон.	100

90	тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна.	2	Мал эмнэлгийн нэгжүүдийн чадавхийг сайжруулах ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг тооцон ажиллах	2023 оны 03-р сарын 19-22-ны өдрүүдэд Малын эмчийн сургалт зөвлөгөөнд тус сумын Баянсаруул, Донбэйс, Бүдүүн хайрхан мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 3 малын эмч, МЭТ-ийн улсын байцаагч нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Мөн мал эмнэлгийн төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалтад тус сумаас Донбэйс МЭҮН-ийн малын эмч Ц.Амаржаргал, МЭУБ Г.Хонгорзул нар, Улаанбаатар хотод малын эмчийн итгэмжлэл олгох сургалтад МЭТ-ийн тархвар зүйч Э.Сосорбарам нар тус тус хамрагдсан. 2024 онд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж ажлуулах хүсэлт гаргасан иргэн Азгэрэл /малын эмч/ мал эмчийн итгэмжлэлийн сургалтад хамрагдсан. Тус сумын мал эмнэлгийн үйлчилгээний 3 нэгжийг удирдлага зүйгээр цаг тухай бүрт нь хангаж ажилласан.	100
91	2.2.7. Атрын IV аяныг орон нутагт хэрэгжүүлж, хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээх, үр сортын болон үр сортын технологийн шинэчлэлийг эрчимжүүлнэ.	1	Тариалан эрхлэгчдийн эзэмшсэн талбайг эргэлтэнд бүрэн оруулах	Өрхтий трейд ХХК 1328 га, Мүкү ХХК 560 га, нийт 1888 га талбайг бүрэн эргэлтэд оруулаад байна. Сумын хэмжээнд улаан буудай 707 га-с 1080 тн, овьёос 40 га-с 45 тн, тосны ургамал 751 га-с 450 тн, чацаргана 28,1 га-с 10,1 тн, төмс 14,2 га-с 24,9 тн, хүнсний ногоо 8,3 га-с 21,5 тн тус тус хураан авсан ба өмнөх оноос улаан буудай 480 тн, овьёос 15 тн, тосны ургамал 200 тн-оор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100
92	2.2.7. Атрын IV аяныг орон нутагт хэрэгжүүлж, хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээх, үр сортын болон үр сортын технологийн шинэчлэлийг эрчимжүүлнэ.	2	Хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээх, үр сортын болон үр сортын технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх	Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Өрхтий трейд, Мүкү ХХК нь 2023 оны 06 сард тариалангийн зориулалтын 2670га талбайг агрохимийн шинжилгээнд хамруулсан.	100
93	2.2.8. Төмс, хүнсний ногоо тариалах талбайг нэмэгдүүлэх, нарийн ногооны нэр төрлийг олшруулах, хүн амын хүнсний ногооны хэрэгцээг хангах хувийг нэмэгдүүлнэ.	1	Төмс, хүнсний ногоо тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангаж үйлдвэрлэлийг механикжуулах	Хүнсний ногооны нэр төрлийг олшруулж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зорилгоор “Шинэ хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд өрхийн тариалан эрхлэх хүсэлтэй Чинхайрхан төв, Лах багийн иргэн Д.Түмэннаст, Хараат багийн иргэн Д.Одонхүү, 4-р багийн иргэн Т.Ганзоригт нарт 4*10 хэмжээтэй 1,637,000 төгрөгний үнэ бүхий 4 ш хүлэмжийг олгосон. Төслийн хүрээнд нийт 8 ш хүлэмжийг иргэдэд олгосон. 2023 оны 04-р сарын 03-ны өдөр “Тариалангийн сэргэлт-2023” нэгдсэн чуулган Төрийн ордонд зохион байгуулагдаж, Лах багийн ногоочин Д.Очиржанцмааг оролцуулж, чадавхжуулсан. 2023 оны 04 сарын 13-ны өдөр “Булган хангайн тариаланчдын сургалт, зөвлөгөөн-2023” арга хэмжээнд 1 тариаланч, 2 ногоочин оролцож, үр тарианы үйлдвэрлэл, төмс, хүнсний ногооны төрөлжсөн сургалтад хамрагдсан. Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 04-р сард өрхийн тариалан эрхэлдэг иргэдээс хүнсний ногооны үрийн захиалга авч, 2023 оны 05-р сарын 05-ны өдөр 13 нэр төрлийн хүнсний ногооны үрийг өрхийн тариалан эрхэлдэг 64 иргэнд 80%-ийн хөнгөлөлттэй үнээр олгосон.	100

94	2.2.10. Малын тэжээлийн ургамал тариалах, үйлдвэрлэлийг бий болгох иргэд, малчид, ААН-үүдийн санал санаачлагыг дэмжиж ажиллана.	1	Малчдын бүлэг, хоршоодыг малын тэжээлийн ургамал тариалах, үйлдвэрлэлийг бий болгох ажлыг дэмжих	Малчдыг бүлгийн зохион байгуулалтад оруулж, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Өрхтий трейд ХХК, Мүкү ХХК-иудын тариалангийн талбайн 200 га газарт малын тэжээлийн ургамал тариалуулах ажлыг зохион байгуулсан.	70
<b>Хөдөө аж ахуйн зорилтын дүн</b>					<b>96</b>
<b>2.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ</b>					
<b>Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх таатай орчныг бүрдүүлэн, орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.</b>					
95		1	ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж төсөл хөтөлбөр, зээл тусламжинд хамруулах	ХЭДС-н төсөл хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг хамруулж, 7 сая төгрөгийн төсөл хөтөлбөрт хамрагдсан. 2023 оны 03-р сарын 23-ны өдрийн сумын ИТХ-ын ээлжит XIII-р хурлаар Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох салбар, чиглэл, зээлийн доод хэмжээ, хөнгөлөлттэй зээлийн тов тогтоолгосон. 2023 оны 05-р сард нийт 4 иргэнд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 106,1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.	100
96	2.3.1. Жижиг, дунд үйлдвэрлэлд санхүүжилтийн олон эх үүсвэрээс дэмжлэг үзүүлэн ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2	ЖДҮ эрхлэгчдийн санал, санаачлагыг дэмжиж, гадаад, дотоодын туршлага судлуулах, мэргэшүүлэх сургалтад хамруулах	2023 оны 04-р сарын 03-ны өдөр "Тариалангийн сэргэлт-2023" нэгдсэн чуулган Төрийн ордонд зохион байгуулагдаж, Лах багийн ногоочин Д.Очиржанцмааг оролцуулж, чадавхжуулсан. 2023 оны 04-р сарын 13-ны өдөр "Булган хангайн тариаланчдын сургалт, зөвлөгөөн-2023" арга хэмжээнд 1 тариаланч, 2 ногоочин оролцож, үр тарианы үйлдвэрлэл, төмс, хүнсний ногооны төрөлжсөн сургалтад хамрагдсан. Мөн Шинэ хөдөө төслийн хүрээнд БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Эрээн хотод туршлага судлах аялалд ногоочин Д.Очиржанцмааг оролцуулсан. Туршлага судлах аялалаар мал нядалгааны хүнсний үйлдвэр, махны үйлдвэр, цагаан идээ боловсруулах өрхийн үйлдвэр, саалийн ферм, бүтээгдэхүүнээ борлуулах нэрийн барааны дэлгүүр, аялал жуулчлалын үндэсний парк, махны чиглэлийн үйлдвэрийн ферм, хөрсгүй хүнсний ногооны тариалах технологи бүхий хүлэмжийн аж ахуй, малын өтөг бууц ашиглан хийж буй органик бордооны үйлдвэр зэрэгтэй танилцаж туршлага судалсан байна.	100
97	2.3.2. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, сумын брэнд бүтээгдэхүүнийг бий болгоно.	2	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бүх шатанд бодлогоор дэмжих, сумын брэнд бүтээгдэхүүн бий болгох	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах зорилгоор 2023 оны 04 сард Хүнс, хөдөө аж ахуйн газар, Германы хамтын ажиллагааны GIZ нийгэмлэгтэй хамтран "Төсөл хэрхэн бичих, хамгаалах" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 15 жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид хамрагдсан. Тус суманд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг Муку ХХК нь Соба гурил, Соба будааг Дашинчилэн суманд үйлдвэрлэн савалж, Монгол улсын зах зээлд гаргаад байна. Мөн Сорог төгөл ХХК, Чилэн арвижих баялаг хоршоод нь өөрийн тариалсан чацарганаар өтгөрүүлсэн чацарганыг үйлдвэрлэн савалж, худалдан борлуулж байна.	100

98		1	Үйлчилгээний ажилчдад зориулсан үйлчилгээний соёлын сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулах	Булган аймагт зохион байгуулагдсан Хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой шинэчлэгдсэн хууль эрхзүйн сургалтад 9 ААН хамрагдаж, “Хариуцлагатай үйлчилгээний гэрчилгээ” авсан.	70
99	2.3.3. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, стандартын хэрэгжилтийг сайжруулна.	2	"Дүнжингарав" ахуй үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, явуулын үйлчилгээ эрхлэх нөхцлийг бүрдүүлэх	2016 онд "Дүнжингарав" ахуйн үйлчилгээний төв ашиглалтад орж, нийт 16 иргэн үсчин, оёдол, хоолны газар, нотариат, шуудан холбоо, бараа материалын худалдаа чиглэлээр, 2022-2023 онд "Таван-Эрдэнэ" ахуй үйлчилгээний төв ашиглалтад орж, нийт 8 иргэн халуун ус, цайны газар, зочид буудал, оёдол чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Ахуй үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаа тогтмолжсон, нийтийн төвлөрсөн халаалтад холбогдсон. Стандарт хэмжилзүйн газраас "Таван-Эрдэнэ" ахуй үйлчилгээний төвийн халуун усанд тохирлын гэрчилгээ олгосон.	100
100		3	Худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж, стандартын хэрэгжилтийг сайжруулах	Согтууруулах ундаа түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдэд хяналт шалгалтыг 11 удаа зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан байна. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулахыг хориглосон захирамжийг 4 удаа гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьсан.	100
<b>Үйлдвэрлэл, үйлчилгээний зорилтын дүн</b>				<b>95</b>	
<b>ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ БҮЛГИЙН ДҮН</b>				<b>97</b>	
<b>ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>					
<b>3.1. Байгаль орчин</b>					
<b>Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.</b>					
101	3.1.1. Байгалийн баялаг болох рашаан, шавар, хужир, элс, хайрга, усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, хэмнэх, нөхөн сэргээх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1	Байгалийн нөөц баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах журмыг боловсруулах	2023 онд Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого 4 сая төгрөг төвлөрүүлэхээс 11 дүгээр сарын байдлаар 2,1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 100 хувь төвлөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	70
102		2	Булаг шанд болон усан хангамжийн эх үүсвэрийн эхийг хашиж, хамгаалах ажлыг зохион байгуулах	2023 онд Лах багийн Түрүүний эхийн булгийг аймгийн Байгаль хамгаалах сангийн 9 сая төгрөгийн хөрөнгөөр "Есөнмөнх" ХХК нь хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хараат багийн Шандны булагийг хаших ажлыг малчдын санаачлагаар хийсэн.	100

103	3.1.2. Ургамал, ан амьтдын биологийн төрөл зүйлийг хамгаалах, өсгөн үржүүлэх санаачилгыг дэмжиж, хамтран хэрэгжүүлнэ.	1	Биологийн төрөл зүйлийн нэгдсэн судалгаатай болох	2023 оны 12 сарын байдлаар "Эмийн ургамал тарималжуулах плантас" нь 8-н төрлийн эмийн ургамал болох Мана, Гүргэм, Татраш, Хумсан цэцэг, Үүсүү, Хунчир, Лэдэр, Чихэр өвсийг тариалах ажлыг зохион байгуулсан байна.	100
104	3.1.4. Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах ажлыг боловсронгуй болгож, орчны бохирдол доройтлыг бууруулна.	1	Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг боловсруулж батлуулах	"Цэвэр орчин-Цэмцгэр Дашинчилэн" хөтөлбөрийн хүрээнд хог хаягдлыг ангилан ялгах, экологийн боловсрол олгох, зөв дадалд хэвшүүлэх сургалтыг төрийн албан хаагчид болон ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулсан. Мөн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажлын хөлсийг ЭБЦТС ТӨХК-тай гэрээ байгуулан төвлөрүүлж байна. Хогны автомашины жолооч, хог ачигчтай гэрээ байгуулан, хог ачих ажлыг хийлгэж байна. Бүх нийтийн хог цэвэрлэгээг 3 дугаар улирлын байдлаар 4 удаа зохион байгуулсан. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн хог цэвэрлэх ажлыг 5 удаа зохион байгуулж, 85 иргэн хамрагдсан.	100
105		3	Хог хаягдал тээвэрлэх автомашиныг шинэчлэх	Аймгийн Байгаль хамгаалах сангийн 70 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хог тээвэрлэх зориулалтын автомашинтай болсон.	100
106		4	Хог хаягдлын нэгдсэн цэгт ландфиллын аргыг нэвтрүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлэх	Нэгдсэн хогийн цэгийн хогийг түрж булах ажлыг 2 удаа зохион байгуулж, 1.8 сая төгрөгийг зарцуулсан.	100
107	3.1.5. "Жорлонгоо өөрчилъе" аяныг жил бүр зохион байгуулж, айл өрх, албан байгууллагыг байгальд ээлтэй боловсон 00-той болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1	Айл өрхийг байгальд ээлтэй боловсон жорлонтой болгох ажлыг зохион байгуулах	"Жорлонгоо өөрчилъе" аяныг сумын хэмжээнд удирдамжийн дагуу зохион байгуулсан. Нийт 31 өрх боловсон 00-той болсон байна.	70
108		2	Инженерийн шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, ААН-үүдийг чанарын шаардлагад нийцсэн ариун цэврийн өрөөтэй болгох	Сумын хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Чулуут нуур амралтын газар, засмал зам дагуу үйл ажиллагаа явуулдаг Элбэг зоогийн газар, зочид буудал, Чин хайрхан зоогийн газар, зочид буудал, ЗДТГ, ЕБС, ЭМТ, Цэцэрлэг зэрэг албан байгууллага, ААН-үүд боловсон 00-той болсон байна. Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж байгаа сургууль, цэцэрлэг, дотуур байрны модон жорлонг халах ажлын хүрээнд тус сумын сургууль дээр эрэгтэй 5, эмэгтэй 5, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1, нийт 11 суултуур, 8 угаалтуур бүхий ариун цэврийн 2 өрөөг 175,0 сая төгрөгний өртөгтэйгээр шинээр байгуулах ажил хийгдэж байна.	100
109	Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-	1	Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх	Цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг 2023 оны байдлаар нийт 48 удаа, давхардсан тоогоор 24960 иргэнд хүргэн ажилласан. Цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээг хүргэх ажилд 200,0 мян төгрөгийг зарцуулсан.	100



	шинжилгээний сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.		чадавхыг урьдчилсан хэрэглэгчдэд хүргэх бэхжүүлж, мэдээг шуурхай		
<b>Байгаль орчны зорилтын дүн</b>					<b>93</b>
<b>3.2. Аялал жуулчлал</b>					
<b>Байгаль, түүх, соёлын өвийн онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжтэй салбар болгон хөгжүүлнэ.</b>					
110	Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар, рашаан сувилал, дэд бүтэц зэрэг давуу талаа түшиглэн сумын аялал жуулчлалын маршрутыг гаргаж, аялагчдын тоог нэмэгдүүлнэ.	1	Түүх, соёлын дурсгалт газрууд, рашаан сувилалын танилцуулга, маршрутыг гарган улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу байрлуулж, түүгээр дайран өнгөрөх аялагчдад сурталчлах ажлыг зохион байгуулах	Улсын хамгаалтад 3, аймгийн хамгаалтад 5, сумын хамгаалтад 12 байдаг түүх, соёлын дурсгалт газрыг дурсгалын ойролцоо нутагладаг малчдад хариуцуулан эзэнжүүлсэн. Улсын хамгаалтан байдаг Цогтын цагаан байшин түүний гэрэлт хөшөөг Ч.Түвдэндамба, Чин толгойг Л.Мөнхбат, Хар бухын балгасыг Ц.Баасанбат, аймгийн хамгаалтад байдаг Хангидай хадны сүг зураг болон Зүрхийн үзүүрийн хүннүгийн оршуулгын дурсгалыг Б.Цэнгэл, Арслант хадны сүг зургийг З.Доржрагчаа, Оорцог уулын хадны сүг зургийг Ч.Санжидсүрэн, Бичигтийн шургуулгын бичээсийг Д.Амармэндэд тус тус хариуцуулсан. Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн бүртгэл мэдээллийн санг баяжуулж, хувийн хэрэг шинээр нээж, Соёлын төвийн номын санч мэдээллийн ажилтанд хариуцуулаад байна.	100
111	Улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэг байгуулах иргэд, ААН-ийн санал санаачлагыг дэмжиж ажиллана.	1	Улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэгтэй болох	Мянганы зам дагуу сумын төвөөс 12км зайд стандартад нийцсэн түр буудаллах цэгийг Хөвчийн зам ХХК байгуулсан. Үүнд автомашины зогсоол, сүүдрэвч, 00, хогийн савийг байрлуулсан.	70
<b>Аялал жуулчлалын зорилтын дүн</b>					<b>85</b>
<b>НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО БҮЛГИЙН ДҮН</b>					<b>89</b>
<b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>					
<b>4.1. Цахим Монгол төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн бодлогыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэнэ.</b>					

112	4.1.1.“Цахим Монгол” төрийн үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлнэ.	1	Мэдээллийн хэрэгсэл, цахим орчинг ашиглан хууль сурталчлах	Дашинчилэн эрх зүйн хөтөч цахим хаягийг тогтмол ажиллуулан, иргэдэд чухал шаардлагатай болон шинээр гарсан хууль тогтоомжийн талаарх мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байна. Эрх зүйн хөтөч цахим сайтад 181 гишүүнтэй болж, нийт 51 хуулийн мэдээллийг байршуулан ажилласан. Нийт давхардсан тоогоор 2710 иргэнд мэдээ мэдээллийг хүргэсэн байна.	100
113	4.1.2. Төрийн байгууллагын үйл ажиллагааны үйл мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангана.	1	Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаан дах иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Ажлын хэсэг болон зөвлөл комисс байгуулахдаа иргэдийн төлөөллийг оролцуулан, үйл ажиллагаа явуулж байна. 2023 оны 06 сарын байдлаар ажлын хэсэг 14, зөвлөл 12, комисс 9 байгуулан ажиллаж байна. “Хүүхэд сонсох өдөр”-ийг 1 удаа зохион байгуулж, 5-11 дүгээр ангийн 14 сурагчдын төлөөллийг хамруулсан. Сурагчид “Найз байя”, “Хайр-Хариуцлага”, “Ногоон байгаль”, “Эерэг хандлага-Эрүүл залуу үе”, “Сумын хөгжилд бидний оролцоо” сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэн, “Хүүхэд бүр нэг мод тарья”, “Цаас бол цэцэг биш” уриалгыг гаргасан байна. “Жендэрийн тэгш байдал ба хэвшмэл ойлголт” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 15 эрэгтэй, 15 эмэгтэй төлөөлөл хамрагдсан.	100
<b>Цахим Монгол төрийн шуурхай үйлчилгээ зорилтын дүн</b>					<b>100</b>
<b>4.2. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба-хүнд сурталгүй төрийн үйлчилгээ чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.</b>					
114	4.2.1. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба-хүнд сурталгүй төрийн үйлчилгээ Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	1	Төрийн албанд иргэнийг авах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр томилох, сургаж хөгжүүлэх бодлого, зохицуулалтыг чадахуйн зарчимд нийцүүлэх	Төрийн захиргааны 4 сул орон тооны захиалгыг аймгийн ТАСЗ-д хүргүүлж, 3 сул орон тоог нөхсөн. Төрийн үйлчилгээний 1 сул орон тоонд чадахуйн зарчмыг үндэслэн төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлсэн. Төрийн үйлчилгээний 1 сул орон тоонд сонгон шалгаруулалтыг явуулж, 1 төрийн албан хаагчийг томилсон.	100
115	Төрийн албаны хүний нөөцийг үе шаттай сургаж, мэргэшүүлэн төрийн албан хаагчдын	2	Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх.	Төрийн байгууллагуудын ёс зүйн хороодыг чадавхжуулах сургалтыг 1 удаа зохион байгуулж, ёс зүйн хороодын 20 гишүүдийг хамруулсан. Булган аймагт зохион байгуулсан ёс зүйн хороодын дарга нарыг чадавхжуулах сургалтад ЗДТГ-ын ёс зүйн хорооны 1 гишүүнийг хамруулсан. Төрийн албан хаагчдад зориулсан ёс зүйн сургалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 48 төрийн албан хаагчийг хамруулсан. Төрийн албанд 1-3 дах жилдээ ажиллаж байгаа залуу төрийн албан хаагчдад зориулсан зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж, 21 төрийн албан хаагчдыг хамруулсан. 2023 онд ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагч байхгүй.	100
116	Төрийн албаны хүний нөөцийг үе шаттай сургаж, мэргэшүүлэн төрийн албан хаагчдын	1	Төрийн албан хаагчдын техник, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх.	УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ "Шинэ хөдөө-Боловсрол" төслийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 19 багшид зөөврийн компьютерыг олгосон. Мөн ЕБС-ийн нөхөн хангалтын зардлаас 11 багшид 32.9 сая төгрөгийн өртөг бүхий зөөврийн компьютер авахаар хүсэлтийг явуулсан байна. ЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 19 сая төгрөгийн өртөг бүхий 5ш нөүтбүүк, ЗДТГ-ын төрийн албан	100

	ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.			хаагчдад 12.8 сая төгрөгийн өртөг бүхий 1ш А3 принтер, 2ш нөүтбүүк, 3ш принтер, ИТХ 15 сая төгрөгийн өртөг бүхий ухаалаг самбар, 1ш принтерийг олгосон байна.	
117		2	Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах	Аймгийн төсвийн 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн барилгад их засвар хийгдсэн. Их засвараар барилгын гадна фасад, сантехник, барилгын дээвэр, цонх, цахилгааны мантажийг шинэчлэх ажил хийгдсэн. Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж байгаа Сургууль, цэцэрлэг, дотуур байрны модон жорлонг халах ажлын хүрээнд тус сургууль дээр эрэгтэй 5, эмэгтэй 5, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1 нийт 11 суултуур, 8 угаалтуур бүхий дотор бие засах газар 175,0 сая төгрөгний өртөгөөр хийгдэж байна.	100
118		3	Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтанд хамруулах	Төрийн албан хаагчдын дунд мэдлэг олгох, хууль эрх зүйн сургалтыг нийт давхардсан тоогоор 6 удаа 13 сэдвийн хүрээнд 156 төрийн албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. 2023 онд шинээр томилогдсон 5 төрийн албан хаагчдад удирдамжийн дагуу дадлагжуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, мэдээллийг 3 удаа өгч ажилласан байна. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 1 төрийн албан хаагчийг хамруулахаар судалгааг ТЗУХ-т хүргүүлсэн. Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 төрийн албан хаагч хувийн зардлаар сурахаар бүртгүүлсэн байна.	100
119	4.2.3. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэнэ.	1	Иргэдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг мэдээг дэд шатны байгууллагад хугацаанд нь мэдээлж ажиллах	2023 оны 3 улирлын байдлаар бүртгэл хяналтанд нийт 71 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна. Өргөдөл, гомдлын дийлэнх хувийг газар олгох болон газрын гэрчилгээ гаргуулах, ногоон тэжээлийн ургамал тариалах газар хүссэн өргөдлүүд эзэлж байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 91%-тай байна. Өргөдөл гомдлыг Dashinchilen.bu.gov.mn сайтаар хүлээн авах боломжтой болсон Цахимаар ирсэн өргөдөл, гомдол байхгүй байна.	100
120	4.2.4. Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулж, төр иргэдийн энэ төрлийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.	1	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх	Төрийн албан хаагчдад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалтыг 1 удаа зохион байгуулж, 28 төрийн албан хаагчийг хамруулсан. 2023 оны байдлаар нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 9 иргэний урьдчилсэн мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулсан.	100
121		2	Төрийн байгууллагуудын шударга байдлын түвшинг тогтоож, дүнг ахиулах	2023 оны байдлаар төрийн байгууллагын шударга байдлын түвшинг тогтоох саналыг 2 удаа цахимаар авах ажлыг зохион байгуулж, дүнг нэгтгэн үр дүнг тооцон ажиллаж байна. Мөн БИНХ-аар иргэдээс цаасаар санал авах ажлыг 4 багийн хүрээнд 1 удаа зохион байгуулсан.	100
<b>Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба-хүнд сурталгүй төрийн үйлчилгээ зорилтын дүн</b>				<b>100</b>	
<b>4.3. Хууль, эрх зүй, батлан хамгаалах Иргэдийн аюулгүй амар тайван байдлыг хангана.</b>					

122	4.3.1. Сумын төвийн камержуулалтын нэгдсэн системийг шинэчлэн засварлаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг авч, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.	1	Төрийн болон төрийн бус байгууллага, ААН-үүдийг камержуулах ажлыг зохион байгуулах.	ЗДТГ, ЭМТ, ЕБС, цэцэрлэг, тусгай зөвшөөрөл бүхий ААН-үүд, 2 ахуй үйлчилгээний төв бүрэн камержсан.	100
123	4.3.1. Сумын төвийн камержуулалтын нэгдсэн системийг шинэчлэн засварлаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг авч, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.	2	Сумын төвийн камержуулалтын нэгдсэн системийг шинэчлэх.	Засмал зам дагуу дөрвөн замын уулзвар, наран хороо, өлзийт хороо, сант хороо, цэцэрлэг хороод камержсан. Дөрвөн замын уулзварт 360 градус эргэдэг, өдөр, шөнө ялгадаг, автомашины номер татах хүчин чадалтай 1 камерыг нэмж байрлуулсан. Сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайд нийт 7 камер ажиллаж байна. 2023 онд ОНХС-ийн 6,5 сая төгрөгийн хөрөнгөөр камержуулалтыг завсарлах, шинэчлэх ажил хийгдсэн.	100
124	4.3.2. Архинд донтогчдод эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.	1	Иргэдийн дунд архины эсрэг соён гэгээрүүлэх ажлыг ТББ-тай хамтран зохион байгуулах	Архины хамааралтай иргэдийн судалгаа болон архи согтууруулах ундаа хэрэглэдэг, бөөгнөрөл үүсгэдэг айл өрхийн судалгааг нарийвчлан гаргасан. Архидан согтуурдаг, бөөгнөрөл үүсгэдэг айл өрхөд хяналт шалгалтыг тогтмол хийж байна. Мөн архины хамаарал бүхий иргэдийн хүүхдүүдтэй уулзаж ярилцан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна. Цагдаагийн хэсэгтэй хамтран архины хамааралтай эмэгтэйчүүдийн ар гэрийхэн, хүүхдүүдтэй уулзаж уулзалт ярилцлага хийж, зөвлөгөө өгсөн. Архи согтууруулах ундааны хор уршигийн талаар Дашинчилэн ЭМТ-ийн фэйсбүүк хуудас, Зөв дадал-Эрүүл мэнд гэсэн цахим хуудсанд мэдээллийг байнга тавьж, цахимаар сурталчилан ажиллаж байна. ЕБС-ийн 5-9-р ангийн сурагчдын дунд "Архи тамхи шинэ үеийн сонголт биш" сарын аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд: 5-9-р ангийн сурагчдын дунд тамхины хор хөнөөлийг таниулах, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. "Зөв хүн байя" сарын аяны хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурагчдад хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн 9-12-р ангийн сурагчдын дунд "Дэвжээ" тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд оролцсон байгуудад тусгайлан бэлдсэн (Архи түүний хор уршиг, Утаат тамхи түүний хор уршиг, Үе энгийн дээрэлхэлт, Гэр бүлийн хүчирхийлэл, Электрон тамхи, Цахим хэрэглээ) сэдвийг өгч, тухайн сэдвүүдийн хүрээнд болсон. Тэмцээнд 7 бүлгийн 42 хүүхэд оролцсон. Зөв дадал-Архигүй орчин бүрдүүлэхээр "Өвлийн өнгө" цасны баяр-2023 арга хэмжээ, Ханьтайгаа хамтдаа" гэр бүлийн тэмцээнийг зохион байгуулсан. Утаат болон электрон тамхи, Үе тэнгийн дээрэлхэлт сэдвүүдээр ЕБС-ийн сурагчдад 1 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 260 гаруй хүүхэд хамрагдсан.	100
125	4.3.3. Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.	1	Төрийн байгууллагуудын архивын баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.	Төр төсвийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан, байгууллагын албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа болон баримт бичгийн стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, албан хэрэгт хөтлөлтийн журам, баримт бичгийн стандартаар 2 удаагийн сургалтыг зохион байгуулж сургалтад Засаг даргын	100

				тамгын газрын албан хаагчид болон байгууллагын дарга, эрхлэгч, архив, бичиг хэргийн ажилтнууд хамрагдан давхардсан тоогоор 71 албан хаагчийг хамруулан заавар зөвлөгөө өгч ажилласан байна. Төрийн албан хаагчаас журмын дагуу баримтыг хүлээн авч 2023 онд нийт 6 төрийн албан хаагчаас байнга-21, түр-10, 70 жил хадгалах 9 баримтуудыг журмын дагуу хүлээн авсан. ЗДТГ-ын архивын баримтад тооллого хийх ажлын хэсэг гарч, 11 дүгээр сарын 15-18 хооронд зохион байгуулсан. ЗДТГ-ын хуучин архивын байрыг шилжүүлэхэд гарсан баримтыг сэргээн засварлах ажлыг хийж төсөвт байгууллагын 2003-2017 оны байнга хадгалагдах баримтыг Төрийн архивт шилжүүлэхтэй холбоотойгоор нөхөн бүрдүүлэлтийг хийж ажилласан. Архивт нийт 1241 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.	
126	4.3.4. Иргэдэд эрх зүйн албан бус боловсрол олгох ажлыг зохион байгуулна.	1	Иргэдэд эрх зүйн болон албан бус боловсрол олгох сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах	"Бүх нийтийн эрх зүйн боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийн хэрэгжилт 10 сарын байдлаар 87 хувийн биелэлттэй байна. Хөтөлбөрийн хүрээнд нийт 14 удаа 26 сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулж, нийт 2148 иргэд хамрагдсан байна. Төрийн албан хаагчдын дунд 6 удаа 14 сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж, 156 албан хаагч хамрагдсан байна. Сумын эрх зүйн хөтөч нарын судалгааг гаргаж, аймгийн Хууль зүйн хэлтэст 1 удаа мэдээлж ажилласан. Эрх зүйн хөтөч нар БИНХ болон баг тойрох, багт ажиллах үеэр шинээр гарсан хууль тогтоомжоор гарын авлага бэлтгэн 1200ш тарааж ажилласан байна. Мөн иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Үндсэн хуулийн өдөрт зориулсан АХА тэмцээн, Монгол цэргийн баярын өдөрт зориулсан "Дөл" тэмцээн, Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах "Бидний бахархал" арга хэмжээ, Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах иргэний хэлэлцүүлэг, Аймгийн Хууль зүйн хэлтэс, цагдаа, прокурорын зөвлөн туслах үйлчилгээ, Малчдын зөвлөгөөний хүрээнд зохион байгуулагдсан "Амьдралын үнэ цэнэ" зэрэг сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 2148 иргэн хамрагдсан. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажилд нийт 5.6 сая төгрөгийг зарцуулсан байна.	100
127		2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчилж ажиллах, төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг тооцож ажиллах	Монгол Улсын Үндсэн хууль, Малын хулгайтай тэмцэх тухай хууль, ГХЗУС тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар гарын авлага материал бэлтгэн, иргэдэд тараах ажлыг зохион байгуулсан. Нийт 98 өрхийн 179 иргэнд гарын авлага материал тарааж ажилласан байна. "Дашинчилэн эрх зүйн хөтөч" цахим сайтаар Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, гарын авлага материалыг байршуулан ажилласан. "Мал мах", "Илрүүлэлт, шийдвэрлэлт" нэгдсэн арга хэмжээг сумын хэмжээнд зохион байгуулсан. 2023 оны байдлаар мал хулгайлах гэмт хэрэг 5 бүртгэгдэж, илрүүлэлт 100 хувьтай байна. "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, хамгаалах хэрэгсэл, мотоцикл" сэдэвт сургалтыг 5 удаа, сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан. Сургалтад нийт давхардсан тоогоор 540 сурагч хамрагдсан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалт,	100

				нөлөөллийн ажлыг хэсэгчилсэн болон ганцаарчилсан байдлаар нийт 42 удаа хийж, давхардсан тоогоор 115 иргэн хамрагдсан байна. Хамгаалах хэрэгсэлгүй хөдөлгөөнд оролцсон 62 иргэнд анхааруулга санамж, мэдээлэл өгч ажилласан.	
128		3	Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулах, үйлчилгээг сайжруулахад анхаарч, ИТХ-тай хамтран ажиллана.	Иргэний танхимаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу 2023 онд 5 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, давхардсан тоогоор 550 иргэний хамруулсан. "Үүнд Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах", "Хадлангийн газрын асуудал", "Мянганы зам дагуу үйл ажиллагаа эрхлэх газрын асуудал", "Өвөлжөө хаваржааны газрын асуудал" зэрэг сэдвээр зохион байгуулсан байна. "Хүүхэд сонсох өдөр"-ийг 1 удаа зохион байгуулж, 5-11 дүгээр ангийн 14 сурагчдын төлөөллийг хамруулсан. Сурагчид "Найз байя", "Хайр-Хариуцлага", "Ногоон байгаль", "Эерэг хандлага-Эрүүл залуу үе", "Сумын хөгжилд бидний оролцоо" сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэн, "Хүүхэд бүр нэг мод тарья", "Цаас бол цэцэг биш" уриалгыг гаргасан байна. "Жендэрийн тэгш байдал ба хэвшмэл ойлголт" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 15 эрэгтэй, 15 эмэгтэй төлөөлөл хамрагдсан.	100
129	4.3.5. Сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, тойм судалгаа хийж, гамшиг аюулт үзэгдлийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, техник тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана.	1	Сумын гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулах, сургалт, дадлага зохион байгуулах	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангид чадавхжуулах сургалтыг 4 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 171 иргэнийг хамруулсан. Үндэсний сөрөн тэсвэрлэх даван туулах чадвар сэдэвт сургалтад 180 иргэнийг хамруулсан.	100
130		2	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн ажиллах нөхцөл, бэлэн байдлыг хангаж, техник зэвсэглэмжийг нэмэгдүүлэх.	Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний дүрэмт хувцас, аранзыг шинэчлэхэд 4.6 сая төгрөг, техник, тоног төхөөрөмжийг /помп, радио холбоо, хүрз, насилк, анхны тусламжийн цүнх, богино долгионы станц/ нэмэгдүүлэхэд 4.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Сумын эрэн хайх аврах бүлгийн байрны засварт 23.6 сая төгрөгийг зарцуулсан байна.	100
131	4.3.6. Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлж, орон нутгийн хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ.	1	Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх, цэргийн насны залуучуудыг дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтанд хамруулах	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан. Төлөвлөгөөнд тодотгол хийн, мэдээг цэргийн штабт хүргүүлсэн. Булган аймгийн Бүрэгхангай суманд зохион байгуулагдсан сургалтад ЗДТГ-ын дарга, 4-н багийн Засаг дарга нар хамрагдсан.	100
132		2	Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх	Батлан хамгаалахын тухай хууль, цэргийн албаны тухай хуулиар ЕБС-ийн ахлах ангийн 10-12 ангийн сурагчдын дунд сургалтыг 1 удаа зохион байгуулж, 18 сурагч хамрагдсан. Сургалтыг бататгах хүрээнд сурагчдын дунд "Дөл" тэмцээнийг зохион байгуулсан. БХЯ-аас зохион байгуулсан "БИДНИЙ БАХАРХАЛ" төслийн арга хэмжээг сумандаа зохион байгуулан явуулсан. Тус арга хэмжээнд ЕБС-ийн 63 сурагч, 204 иргэнийг хамруулсан байна.	100

Хууль эрхзүй, батлан хамгаалах зорилтын дүн			100		
ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО БҮЛГИЙН ДҮН			100		
<b>ТАВ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>					
<b>5.1. Орон нутгийн хөгжил</b>					
<b>Орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.</b>					
133	5.1.1. Албан байгууллага, ААН, айл өрхийг төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэх, цэвэрлэх байгууламжийг барих ажлыг эхлүүлнэ.	1	Ус хангамжийн шугам, сүлжээг үе шаттайгаар ашиглалтанд оруулах	Дашинчилэн сумын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын 2,6 тэр бум төгрөгийн өртөг бүхий зураг төслийг хийлгэж, 2024 оны улсын төсөвт тусгагдсан. Сумын хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Чулуут нуур амралтын газар, засмал зам дагуу үйл ажиллагаа явуулдаг Элбэг зоогийн газар, зочид буудал, Чин хайрхан зоогийн газар, зочид буудал боловсон 00-той болсон. ЗДТГ, ЭМТ, Цэцэрлэг 2020-2022 онуудад ариун цэврийн өрөөтэй болсон. Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж байгаа сургууль, цэцэрлэг, дотуур байрны модон жорлонг халах ажлын хүрээнд тус сумын сургууль дээр эрэгтэй 5, эмэгтэй 5, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1, нийт 11 суултуур, 8 угаалтуур бүхий ариун цэврийн 2 өрөөг 175,0 сая төгрөгний өртөгтэйгээр шинээр байгуулах ажил хийгдэж байна. Сумын хэмжээнд 31 өрх боловсон 00-той болсон.	100
134		2	Ариутгах татуургын шугам, цэвэрлэх байгууламж барьж ашиглалтанд үе шаттайгаар оруулах	100	
135		3	Албан байгууллага, ААН, айл өрхийг төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэх	100	
136	5.1.2. Өрхийн орлогод нийцсэн, амины, түрээсийн гэх мэт инженерийн шийдэл бүхий орон сууцыг барих ажлыг эхлүүлнэ.	1	Сумын төвд 16-аас доошгүй айл өрхийн орон сууц барих ААН, хувийн хэвшлийн санал, санаачлагыг дэмжиж ажиллах	Тодорхой ажил хийгдээгүй.	0
137	5.1.3. Сумын төвийн 3,4 км сайжруулсан замыг хатуу хучилттай болгоно.	1	Сумын төвийн 3,4 км сайжруулсан замыг хатуу хучилттай болгох	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1.3 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэй сумын төвийн 1.8 км хатуу хучилттай авто зам, 3.6 км урттай явган хүний замын ажил хийгдсэн. Гүйцэтгэгчээр "Таван богд оффрөүд" ХХК ажиллаж, замыг хүлээлгэн өгөөд байна.	100
138	5.1.5. Цахилгаан, эрчим хүчний хангамжийг сайжруулж, найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.	2	Сумын төвийн шинэ суурьшлийн бүсэд баригдсан станцаас 0.4-ийн агаарын шугам татах	Сумын төвийн шинэ суурьшлийн бүсийн 1000м газарт 0.4-ийн агаарын шурам татах ажлыг ЭБЦТС ТӨХК хийж гүйцэтгэсэн. ЭХЯ-ны 181 сая төгрөгийн санхүүжилтээр засмал замын хойгуур эрчим хүч татах ажил хийгдэж байна.	100

139	5.1.6. Цөлжилтийн төлөв байдлын судалгаанд үндэслэн тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1	Цөлжилт элсний нүүдлийг тогтоох ойн зурвас байгуулах	Аймгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр "Хөвөнтөн ой" ХХК нь элсний нүүдлээс хамгаалах зурвас 5 га талбайд 5400ш модыг тарьсан. Батбродерс Майнинг ХХК 6 га талбайд 20000 ш мод тарьсан.	100
140	5.1.7. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлтүүдийг тусган батлуулж, хөгжлийн хэтийн зорилт, сум төлөвлөлттэй уялдуулан газар олголтын үйл ажиллагааг ил тод болгоно.	1	5.1.7. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлтүүдийг тусган батлуулж, хөгжлийн хэтийн зорилт, сум төлөвлөлттэй уялдуулан газар олголтын үйл ажиллагааг ил тод болгоно.	"Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлыг "Өрнөх гүнт" ХХК-тай 21.3 сая төгрөгийн гэрээг байгуулан гүйцэтгүүлж байна. Сумын 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/65 захирамжаар байгуулан ажиллаж байна. 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 7 нэгж талбарын 2,5 га газар тусгагдсан. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олголтуудыг зохион байгуулаад байна. Үүнд: Өмчлөлөөр нийт 1,3 га газрыг нийт 6 иргэнд шинээр өмчлүүлээд байна. Эзэмшлээр нийт 7 иргэнд өвөлжөө, хаваржааны зориулалтаар 1,7 га газрыг сумын Засаг даргын 2023 оны А/22, А/103 дугаар захирамжаар, 7 нэгж талбарын дуудлага худалдааг зарласан боловч иргэн оролцоогүй. Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгох зориулалтаар цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбайн барих зориулалтаар 3,5 га газрыг ЗД-ын 2023 оны А/97 дугаар захирамжаар, багийн төв барих зориулалтаар 1 га газрыг 2023 оны А/98 дугаар захирамжаар тус тус ЗДТГ-т эзэмшүүлээд байна.	100
141	5.1.8. Жишиг гудамж, хороолол байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	1	Жишиг гудамж байгуулах ажлыг иргэдийн санал санаачлага, оролцоонд түшиглэн зохион байгуулах	Ажил хийгдээгүй	0
142	5.1.9 Сумын наадмын талбай, биеийн тамир, спортын талбайг шинээр байгуулах, цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбайг засварлах	1	Наран хороонд хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулах	Наран хороонд сумын ОНХС-ийн 40.2 сая төгрөгийн хөрөнгөөр хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулсан. Мөн 2024 оны улсын төсөвт 200 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хүүхдийн тоглоомын талбайн ажил тусгагдсан.	70
143	5.1.9 Сумын наадмын талбайг засварлах	3	Сумын наадмын талбайг шинээр барих	Наадмын талбайн зураг төсөв хийлгэх ажлыг Халзан дуулга ХХК-тай 26 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.	70
144	5.1.10. Сумын гудамж, нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.	1	Гудамж, хорооллыг иргэдийн санаачлага, оролцоонд тулгуурлан гэрэлтүүлэгтэй болгох, нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн засварлах	Сумын төвийн гэрэлтүүлгийн хэмжээг нэмэгдүүлэх, засварлах ажлыг ОНХС-ийн хөрөнгөөр иргэн Ц.Баясгалантай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлээ. Тус ажлын хүрээнд засмал зам дагуух гэрэлтүүлгийн кабел зөөх, явган хүний замын 60ш гэрлийг нэмэлтээр, 11ш гэрлийг шинээр суурилуулах, 42ш гэрлийг туузан ороох, 12ш гэрлийн толгойг солих ажил хийгдлээ. Мөн төр, төсвийн байгууллагууд, хүүхдийн тоглоомын талбайн орчмыг гэрэлтүүлэх ажил хийгдсэн байна.	100



145	5.1.11 Сумын 100 жилийн ойг угтсан бүтээлч ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулна.	1	Сумын 100 жилийн ойг угтсан бүтээлч ажлын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг хангуулах	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн XV/02 тоот тогтоолоор Дашинчилэн сум үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтаж хийх “ДАШИНЧИЛЭН-100” бүтээлч ажлын жагсаалтыг баталж, эзэнжүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Дашинчилэн 100 бүтээлч ажлын хүрээнд 2023 онд 4.6 тэр бум төгрөгийн өртөг бүхий дотуур байрны барилга барих, цэцэрлэгийн барилгын их засвар, засмал зам, ундны усны эрэл хайгуулын ажил, орон нутаг судлах танхимын засварын ажил, соёлын төвийн лед дэлгэц, малчдын зөвлөгөөн, эрдэм шинжилгээний хурал зэрэг ажлууд хийгдсэн байна. 2024 онд улсын төсвийн 2.6 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна инженерийн шугам сүлжээ, 200 сая төгрөгийн өртөгө бүхий хүүхдийн тоглоомын талбай, азийн хөгжлийн банк болон аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5.6 тэр бум төгрөгийн өртөг бүхий 15 ортой жишиг эрүүл мэндийн төвийн барилга, аймгийн төсвийн хөрөнгөөр 320 сая төгрөгийн өртөг бүхий ЕБС-ийн биеийн тамирын спорт талбай, сумын ОНХС-ийн хөрөнгөөр наадмын талбай, хүндэтгэлийн талбайн тохижжилт, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, гэрэлт гудамж байгуулах зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөн байна.	100
<b>БҮС ОРОНЫ НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ДҮН</b>				80	
<b>ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ II ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>				<b>92</b>	

ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН:  
ХЭЗХМ                                  Б.БАТЦЭЦЭГ

ХЯНАСАН:  
ЗДТГ-ЫН ДАРГА                                  Ц.БОЛОРЦЭЦЭГ